



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,

Чингис хот, Хэнтий аймаг, 23117

Утас/Факс: (976) 7056 2412

Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2025. 12. 10 № 9/2596

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тус аймаг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан 102 заалтын 2025 оны биелэлтийг хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

ДАРГА



А.ЖАРГАЛСАЙХАН

231072956

Засгийн газрын 2024 - 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Д/д	Зорилго	Зорилт	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэлийн хувь	Өссөн дүн	Хэрэгжилт	Санхүүжилтийн гүйцэтгэл	Санхүүжилтийн эх үүсвэр
НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
1.1. Улаанбаатар хот-"20 минутын хот" стандарт								
	1.1.1. Хот төлөвлөлт, засаглалын шинэчлэл	1.1.1.2. Хот төлөвлөлт, орчны стандарт алдагдсан орон сууцны хорооллуудад газар чөлөөлөлт хийж, орчны төлөвлөлтийг стандартад нийцүүлнэ.	5. Орон сууцны хорооллуудад хот байгуулалт, барилгын хяналтыг хэрэгжүүлж, төлөвлөлтийг норм, стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулах	100%	100%	Хэнтий аймгийн төв буюу Хэрлэн сумын 3-р багийн нутаг дэвсгэрт "Шинэ Өндөрхаан" орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө 2013 онд батлагдаж, 2015-2020 онуудад дэд бүтцийн бүтээн байгуулалт бүрэн хийгдэж, одоогийн байдлаар нийт 457 айлын 11 блок орон сууц, 920 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэг баригдсан ба энэ онд 154 айлын 3 блок орон сууц баригдаж байна. Мөн Хэрлэн сумын 4-р багийн нутаг дэвсгэрт 2,3га газарт 8 блок 441 айлын "Хэнтий стандарт" орон сууцны хотхон баригдахаар хэсэгчилсэн ЕТ-ий зураг төсөл батлагдаж 2023 оны 3-р улирлаас эхлэн эхний ээлжийн 3 блок орон сууцны барилгыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд "Эм Си Эс Си" ХХК барьж байна. Түүнчлэн хувийн хэвшлийн хөрөнгөөр Хэрлэн сумын 3-р багт "Тугдам Вилла" 308 айлын 16 давхар 4 блок үйлчилгээтэй орон сууцны хотхон батлагдсан хэсэгчилсэн ЕТ-ний дагуу 2024 оны 4-р улирлаас эхлэн баригдаж байгаа бол Хэрлэн сумын 2-р багт "Старкатеринг" ХХК-ийн захиалгаар 96 айлын 2 блок орон сууцны барилга 2025 оны 2-р улирлаас эхлэн баригдаж эхлээд байна. Эдгээр орон сууцны хорооллуудад хот байгуулалт, барилгын хяналтыг хэрэгжүүлэх ажлыг холбогдох хууль, дүрмийн дагуу зохион байгуулан ажиллаж байна.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
			31. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, холбогдох дүрэм, журмыг шинэчлэх	100%	100%	Хэрлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт банкны байрны гэр хорооллын 1 га газрыг дахин төлөвлөж барилгажуулах төсөл хэрэгжиж байгаа бөгөөд гүйцэтгэгчээр "АТТАЧР" ХХК шалгарсан. Төсөл хэрэгжүүлэхээр сонгосон талбай дахь 23 айлын газрыг чөлөөлж 2 өрөө орон сууцаар солихоор тохиролцож төсөлд оролцогчдын хооронд гурван талт гэрээ байгуулагдаад байна. Тус төслийн хүрээнд нийт 288 айлын 4 блок, 12 давхар орон сууцны хотхон баригдах юм. Мөн ХББОСЯамнаас аймагт хэрэгжиж буй дахин төлөвлөлтийн төслийн судалгааг гаргаж 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 03/261 дугаар албан бичгээр яаманд хүргүүлсэн.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй

	1.1.3. Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт	1.1.3.4. Хот, суурин газрыг дахин төлөвлөн хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	32. Нийслэл, орон нутагт хот дахин төлөвлөлтийн төслүүдийг хэрэгжүүлж, инженерийн шугам сүлжээг төлөвлөн барих	90%	90%	Чингис хотын бохир усны төв коллекторын шугамын шинэчлэл, өргөх станц /Хэрлэн сум/-ын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хэрлэн сум, 1, 2,3,4,5 дугаар баг/1-р багийн ажлын байнгын ашиглалтад оруулсан. 2-р багийн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй, айлуудын газарт трасс давхацсаны улмаас ажил удааширч байна. 3-р багийн шугам сүлжээний ажил 85 хувийн гүйцэтгэлтэй, 4,5-р багийн ажил 1 багц бөгөөд одоогоор 5-р багийн шугам сүлжээний ажил 55 хувийн гүйцэтгэлтэй, зуухны карзакны ажил хийгдээд байна. Бохирын ажил бүрэн дууссан. Дулаан цэвэр усны шугамын худаг цутгах ажлууд хийгдсэн. Ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж /Өмнөдэлгэр сум/ -ын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй. Ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, цэвэр усан хангамж, усан сангийн байгууламж /Жаргалтхаан сум/-ын ажил 100 хувь дуусч байнгын ашиглалтад оруулсан. Инженерийн шугам сүлжээний 7 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл 85 хувийн дундажтай байна.	46497.2	Улсын төсөв
			33. 2002 оноос өмнө баригдсан барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ хийж, паспортжуулалтын	0%	0%	Аймаг болон сумд тухайн жилийнхээ төсвийн 1-ээс дээш хувийг гамшгаас хамгаалах чиглэлээр барилга байгууламжийг паспортжуулж газар хөдлөлтөд тэсвэртэй болгох арга хэмжээ авахаар заасан байдаг. 2025 онд тус ажил төсөвт суугдаагүйгээс хэрэгжээгүй.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
	1.1.4. Ногоон - ухаалаг хот	1.1.4.1. Хууль бусаар олгосон газрыг нийтийн эзэмшлийн газар болгож, уг газарт ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн барьж, хотын иргэн оршин суугаа газраасаа 400 метр дотор амарч, тухлах нөхцөлийг бүрдүүлнэ.	43. Хот, суурин газрын ногоон байгууламжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Х.Б	Х.Б	Хуулийн төсөл санаалчлах эрх бүхий субъект биш тул хасуулах саналтай.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
1.4. Орон нутгийн хөгжил								
1.4.1.	Шилжилт	1.4.1.5. Бүсийн хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгааг хангах төсөл, арга хэмжээ, түрээсийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	144. "Миний сонголт-Төрийн алба" орон нутагт төрийн албан хаагчдын түрээсийн орон сууц барих	50%	50%	ХББОСЯамнаас хэрэгжүүлж буй "Төрийн албан хаагчдын орон сууцны цогц хөтөлбөр"-т Жаргалтхаан суманд Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууц, Хэрлэн, Биндэр суманд Төрийн албан хаагчдын 15 айлын орон сууц баригдахаар 3 сум хамрагдаж төсөв батлагдан хэрэгжиж эхлээд байна. Жаргалтхаан сумын Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны барилга угсралтын ажил 3-р улиралд эхэлсэн бол Хэрлэн, Биндэр сумын Төрийн албан хаагчдын 15 айлын орон сууцны төслийн гүйцэтгэгч энэ оны 3-р улиралд шалгарч зураг төслийн шатандаа явж байна.	3200	Улсын төсөв

	хөдөлгөөн	1.4.1.8. Аймаг, нийслэл, сумын хот байгуулалтын баримт бичгийг бүсүүдийн эдийн засагт гүйцэтгэх чиг үүрэгтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.	148. Аймаг, сум, орон нутгийн хөгжлийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах	70%	70%	2025 онд Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй 16 сум, 2 тосгон Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг боловсруулахаар аймгийн болон сумын орон нутгийн төсөвт нийт 2.2 тэрбум төгрөг батлагдсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 14 сум буюу Өмнөдэлгэр, Галшар, Баян-Овоо, Цэнхэрмандал, Дархан, Жаргалтхаан, Дэлгэрхаан, Батноров, Баянмөнх, Биндэр, Баян-Адарга, Норовлин, Дадал, Мөрөн сумдын гүйцэтгэгч шалгарч Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж эхэлсэн ба дундын болон эцсийн тайлангийн шатандаа хэрэгжиж байна.	2200	Орон нутгийн төсөв
		1.4.2.1. Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.	150. Орон нутагт шуудангийн илгээмжийн логикийн дэд төв байгуулах	30%	30%	1. Зүүн бүсийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Хөдөө аж ахуйн цогцолбор парк байгуулах 10га газрын асуудлыг Хэрлэн сумын 2026 оны Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд оруулахаар байршлыг тодорхойлон кадастрын зургийг бэлэн болгосон. Хэрлэн сумын ИТХ 12 дугаар сарын 16-ны өдөр хуралдаж газрын шийдвэр гарна. Төслийн ТЭЗҮ боловсруулагдаж БХТөвийн мэргэжлийн зөвлөлөөс дүгнэлт гаргуулж, аймгийн удирдлага болон холбогдох байгууллагуудаас санал авсан. Одоо БХТөвийн магадлалаар орохоор хүргэгдээд байна. 2.“Харилцаа холбоо, мэдээллийн технологийн зүүн бүсийн чуулган 2025” зохион байгуулагдах үеэр аймгийн Засаг дарга "Монгол шуудан" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд орон нутагт шуудангийн илгээмжийн “Зүүн бүсийн шуудан логикийн төв” байгуулах ажлын хүрээнд тус төвийг байгуулахад шаардлагатай 5 га газрыг Мөрөн сумын 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн сумын ИТХ-ын ээлжит бус хурлаар 2025 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотгол оруулж шийдвэрлүүлсэн. "Монгол шуудан" ХХК-ийн хөрөнгө оруулалт шийдвэрлэгдээгүй тул хэрэгжиж эхлээгүй байна.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй

1.4.2. Орон нутгийн хөгжлийн үйлдвэр	1.4.2.2. Стандартын шаардлага хангасан хүнс, эм, хүрээлэн буй орчны бүсчилсэн лабораторийн нэгдсэн тогтолцоог бий болгож хөгжүүлнэ.	155. Төв болон бүсийн итгэмжлэгдсэн лавлагаа лабораторийн чадавхыг сайжруулах	70%	70%	Үндэсний итгэмжлэлийн төвийн магадлан итгэмжлэлийн ажлын хэсэг аймаг дахь Зүүн бүсийн аймгийн Барилгын материалын лабораторид дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээ хийж 2025 оны 1 дүгээр сард магадлагдан итгэмжлэгдсэн. Лабораторийн байрыг сайжруулах зорилгоор улсын төсвийн 1,384.0 сая төгрөгийн хөрөнгөөр 395м2, 2 давхар өргөтгөлийн барилга барих ажил хэрэгжиж гүйцэтгэгчээр "Хан багана" ХХК шалгарч гүйцэтгэл 75%-тай ажил үргэлжилж байна. Гэрээний дагуу 2026 оны 04 дүгээр сард ашиглалтад орно. Одоогийн байдлаар барилгын материалын лаборатори нь 34 нэр төрлийн барилгын материалыг шинжлэхэд 30 төрлийн тоног төхөөрөмжийг ашиглаж хэвийн үйл ажиллагаа явуулж байна. Стандарт хэмжилзүйн хэлтсийн бүсийн лабораторийн барилгын иж бүрэн ажлын зураг төсөл батлагдсан. 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгах саналыг хүргүүлсэн ч батлагдаагүй байна. Мал эмнэлгийн бүсийн лабораторийн барилгын зураг төсөл боловсруулагдаж холбогдох мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөх шатанд үргэлжилж байна.	650	Улсын төсөв
	1.4.2.3. Бүсүүдийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудыг төрөлжүүлэн хөгжүүлнэ.	156. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудыг төрөлжүүлэх	100%	100%	Бор-Өндөр МБС нь 20 хөтөлбөрөөр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бөгөөд үүний 19 хөтөлбөр нь "Инженерчлэл, үйлдвэрлэл барилга байгууламж" гэсэн ерөнхий чиглэл хамаарах бөгөөд 90 орчим хувь нь уул уурхайн мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрөөр төрөлжсөн. Бор-Өндөр Үйлдвэрлэл технологийн парк нь төслийг хэрэгжүүлэгч Эрдэнэс Үйлдвэрлэл технологийн парк ХХК-тай 2025.09.24-ний өдөр хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Хамтын ажиллагааны санамж бичигт 2030 он хүртэл төсөлд шаардлагатай ажиллах хүчнийг үе шаттайгаар бэлтгэх, багшийн хөгжлийг дэмжих, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах зэрэг ажлууд туссан. Хэнтий аймаг дахь магадлан итгэмжлэгдсэн Политехникийн коллеж нь бүсчилсэн хөгжлийн чиглэлийн дагуу аялал жуулчлал, эрчимжсэн мал аж ахуйг тэргүүлэх чиглэл болгож, элсэлтийн ажлаа зохион байгуулж, багшлах боловсон хүчнээ чадавхжуулах сургалтад хамруулж байна. Сургалт эрхэлж буй техникийн боловсролын Барилга угсралтын техникч 1.5, Барилгын цахилгаан техникч 1.5, техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн дүгнэлтийг Боловсролын ерөнхий газрын Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ хариуцсан мэргэжилтнээр гаргуулсан.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй

	АХЛАЗАГЧИЙН ЗОРИЛТ	НИЙТЛЭЛ	1.4.2.4. Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан орон нутгийн иргэдэд нарийн мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллагыг төрөлжүүлнэ.	157. Ахлах сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэх	70%	70%	2025-2026 оны хичээлийн жилд ахлах сургуулийн төрөлжилтөд шаардагдах орчны бэлтгэл, сургалтын агуулга, багшийн нөөцийн судалгаа хийж Боловсролын сайдад албан бичгээр хүргүүлээд байна. Эхний ээлжид Хэрлэн-1, Хэрлэн 3, Хэрлэн-4, Бор-Өндөр, Өмнөдэлгэр сумдын ЕБС -д математик, байгалийн ухаан, монгол хэл хичээлээр төрөлжүүлэн сургалт хийгдэж байна. Жаргалтхаан сумын ЕБС-ийг мэдээллийн технологи чиглэлээр төрөлжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2025-2026 оны хичээлийн жилд төрөлжсөн ахлах сургуулийг нээн хичээллүүлэх боломжгүй байгаа талаарх мэдээллээ Боловсролын сайдад албан бичгээр хүргүүлээд байна. Бор-Өндөр болон Хэрлэн суманд шинэ сургуулийн барилга баригдсан тохиолдолд төрөлжсөн ахлах сургууль нээн ажиллуулах боломж бүрдэнэ.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
			1.4.2.6. Хот, суурин газруудын хүн амын ундны цэвэр усны шугамыг зэс шугамаар сольж, ундны усны чанар, аюулгүй байдлыг хангана.	160. Хот, суурин газруудын хүн амын ундны цэвэр усны шугамыг зэс шугамаар солих судалгаа хийж, загвар төсөл хэрэгжүүлэх	70%	70%	Чингис хот, Бор-Өндөр, Дэлгэрхаан сумдын ундны усны эх үүсвэрийн худгуудыг дотоодын цэргийн хамгаалалтад бүрэн шилжүүлж аюулгүй байдлыг хангаж байна. Хэнтий аймгийн цэвэр усны шугам сүлжээнд угаалга хийх ажлыг үе шаттай зохион байгуулах зорилгоор 2026 оны орон нутгийн төсөвт угаалгын компрессор худалдан авах хөрөнгө оруулалтыг тусгасан. Чингис хотын ундны усны эх үүсвэрийн байгууламжид хлоржуулалтын төхөөрөмж суурилуулан ариутгал, халдваргүйжүүлэлт хийж чанар стандартад хяналт тавьж байна. Мөн Галшар сумын эх үүсвэрийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулсан.	151	Холимог эх үүсвэр
				161. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороог байгуулж, хот, суурин газрын агаарын бохирдлын эх үүсвэрийг бууруулах нэгдсэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	90%	90%	Чингис хотын агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, бүсэд мөрдөх журмыг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, нөлөөллийн шинжилгээ хийж, тайлан мэдээний хамт БОУАӨЯаманд хүргүүлж Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, аймгийн Засаг даргын хамтарсан шийдвэр А/830,А/583 дугаартай тушаал/захирамжаар батлуулсан. Журамд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх 18, төрийн байгууллагуудын дагаж мөрдөх 9 эрх, үүргийг тусгасан ба хариуцсан байгууллагуудад чиглэл өгч хэрэгжилтийг 90 хувьтай хангуулж ажиллаж байна. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооноос боловсруулж буй "Хот, суурин газрын агаарын бохирдлын эх үүсвэрийг бууруулах нэгдсэн төлөвлөгөө"-нд албан тоотоор холбогдох саналаа хүргүүлсэн.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй

		1.4.2.7. Аймгийн төвүүд болон томоохон хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулна.	162. Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн усан болон уурын халаалтын зууханд технологийн шинэчлэлт хийж, дулаан хангамжийг төвлөрсөн дулаан болон хийн, сэргээгдэх эрчим хүчний бусад эх үүсвэрт шилжүүлснээр хатуу түлшний хэрэглээг бууруулах	50%	50%	“Дулааны станц” төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц /Хэнтий, Хэрлэн сум/ нь 3 багцад хуваагдан хэрэгжсэн бөгөөд Багц-2 /Усан хангамж, ариутгах татуурга/-ын 600 м бохир, 700 м цэвэр усны шугамын ажил 100% дууссан. Багц-1 /Цахилгаан хангамж/ болон Багц-3 /Холбоо мэдээлэл/ төслүүд 100% хэрэгжиж, улсын комисс ажиллуулахад бэлэн болсон. Мөн 2025 оны ОНХСангийн хөрөнгө оруулалтаар “Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам засвар, шинэчлэл - 4 дүгээр ээлж” ажлын зураг төслийг 100% дуусгаж хүлээлгэн өгсөн. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ-ыг ЦЭХ-ээр хангах 60квт-ын нарны эх үүсгүүр суурилуулан ашиглалтад оруулсан. ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар иргэдэд үйлчлэх “Хурдан” төвийн нарны толь суулгах, цахилгаан машины цэнэглэгч суурилуулах” төсөл хэрэгжиж ашиглалтад оруулсан. Мөн Цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга бага чадлын 2 кВт хүчин чадалтай нарны эх үүсгүүр суурилуулж аваарын үед ашиглаж байна. Дулааны станц ашиглалтад орсноор хэрэглэгчид дулаан хангамжийн найдвартай эх үүсвэрээр хангагдаж байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө буурна. Нүүрсний хэрэглээ 40-50% хүртэл, үнсний гаралт 25% хүртэл буурах юм.	3174	Улсын төсөв
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
2.1. Чинээлэг Монгол хүн								
		2.1.1.2. Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, "Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	167. "Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо" хөтөлбөр хэрэгжүүлэх	90%	90%	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 5 дугаар хуралдааны 9 дүгээр тогтоолоор Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын салбар дундын “Ирээдүйн эзэд” хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/239 дүгээр захирамжаар батлуулж, сумдын Засаг дарга нарт хяналтад авч ажиллах чиглэлийг хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 91,5 хувьтай байна.	80	Орон нутгийн төсөв
		2.1.1.3. Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	169. Гэр бүлд зориулсан нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний цахим платформ хөгжүүлэх	30%	30%	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэр бүлийн хөгжлийн цахим үйлчилгээний E-Family платформыг 2025 оноос хөгжүүлж, ажиллуулахаар бэлтгэж байгаа ба тус ажлын хүрээнд платформын талаар албан хаагчдад мэдээлэл хүргэн ажилласан.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй

		2.1.1.4. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	171. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулах	100%	100%	Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв байгуулах ажлыг аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/95 дугаар захирамжаар 2 бүсийн Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг Батноров, Бор-Өндөр сумдад байгуулсан.	60	Орон нутгийн төсөв
			172. Гэр бүлийн гишүүн бүрд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамруулах	100%	100%	Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвөөр дамжуулан 2 бүсэд нийт 7 төрлийн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулж, нийт 2500 хүнийг хамруулсан. Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд 193, бүлгийн зөвлөгөөнд 253, нийт 446 гэр бүл сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамрагдаж, өмнөх оноос сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ авсан гэр бүлийн тоо 64,5 хувь нэмэгдсэн байна.	10	Орон нутгийн төсөв
		2.1.1.5. Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, гэр бүл төвтэй, салбар дундын хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлнэ.	173. Хүүхэд хамгааллын кейс менежмент, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг хөгжүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээг шаардлагатай	100%	100%	Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг илрүүлэх, судлан тогтоох, хяналт тавих, гэр эргэлтийн ажлыг 4 удаа зохион байгуулж, 756 өрхийн 1381 хүүхдэд хүрч ажилласан. Өндөр эрсдэлтэй 45 өрхөд кейс нээж шаардлагатай тусламж дэмжлэгийг 100 хувь үзүүлсэн.	6.47	Улсын төсөв
			174. Эцэг, эх, хүүхэд, олон нийтэд болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг амьдралд хэрэгжүүлнэ.	100%	100%	Жилийн эцсийн байдлаар урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 26 үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт 35679 иргэнийг хамруулсан. Нийт хүн амын 45,1 хувьд хүрч ажилласан.	237.6	Орон нутгийн төсөв, Улсын төсөв
2.1.1. Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн боллого		2.1.1.6. Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог иргэд, олон нийтийн оролцоотой бүрдүүлж, гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулна.	177. Сум, хорооны олон нийтийн байцаагчдыг сурган чадавхжуулах замаар эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн илрүүлэлтийг сайжруулж, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах	100%	100%	Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/33 дугаартай захирамжаар Хэрлэн сумын 6 багт 42 хэсгийн ахлагчийг “Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч”-аар томилон, 4 удаа сурган чадавхжуулж ажиллуулсан. Хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэх “Та хаана хандах вэ?” аян зарлаж 108 тусгай дугаарын утсанд зөрчлийн мэдээлэл бүрийг тухай бүр мэдээлж ажилласны үр дүнд 108 тусгай дугаарын утасны дуудлага 251 болж өссөн буюу илрүүлэлтийг 3 дахин нэмэгдүүлсэн. Жилийн эцсийн байдлаар хүүхдийн эрхийн зөрчлийн дуудлага мэдээлэл нийт 251 бүртгэгдэж, тус дуудлага мэдээлэлд холбогдох 570 хүүхдэд, 2115 удаагийн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж, шаардлагатай үйлчилгээг 100 хувь хүргэж ажилласан.	32.76	Орон нутгийн төсөв

		2.1.1.7. Сум, хороо бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж, хүүхдийн хөгжих таатай орчныг бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, хөгжил, хамгааллын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэнэ.	178. Сум, хороо бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан шинээр ажиллуулж, мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулах	100%	100%	Хэнтий аймгийн суманд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоо Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 237 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан квотоор 27 байхаар батлагдсан. Батлагдсан квотын дагуу хүүхэд, хамгааллын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд сум хариуцан ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан 27 томилж хүний нөөцийн бүрдүүлэлтийг 100 хувь ханган ажиллаж байна. Шинээр томилогдсон нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах 5 удаагийн сургалт, 1 удаагийн зөвлөгөөн зохион байгуулж давхардсан тоогоор 121 хүүхэд, нийгмийн ажилтныг хамруулсан.	10	Орон нутгийн төсөв
		2.1.1.20. Ахмад настныг шинэ ур чадварт сургах, ажил, хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.	196. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх	100%	100%	Ахмад настныг ажил хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх боломжийг дэмжин “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг үзүүлэх” арга хэмжээнд 47 ахмадын төслийг шалгаруулан 250,000,000 төгрөгний санхүүжилтийг олгоод байна. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 70 ахмад мэргэжилтнийг түр ажлын байраар хангаж, 75,600,000 төгрөгийг зарцуулсан.	75.6	Орон нутгийн төсөв
		2.1.1.26. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх аймаг, дүүрэгт байгуулна.	210. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг аймаг, дүүрэгт байгуулах	100%	100%	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үйлчилгээг нэгтгэн үйлчилгээний орчин хүртээмжийг сайжруулах чиглэлээр орон нутгийн төсөвт 20,000,0 төгрөгийг шийдвэрлэж ахмадын хорооны 1 давхрыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв болгон тохижуулж хүртээмжийг сайжруулсан.	20	Орон нутгийн төсөв

		2.1.1.30. 2025 оныг "Залуучуудын жил" болгон зарлаж, оюутан, залуучуудын чөлөөт цагаараа ажил, хөдөлмөр эрхлэх, гарааны цогц арга хэмжээг бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайжруулж, нийгмийн идэвх, оролцоог дэмжинэ.	218. Залуучуудыг дэмжих цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	90%	90%	Хэнтий аймгийн 15-34 насны өсвөр үе, залуучуудыг чадавхжуулах зорилгоор нийт 7 төрлийн сургалт, өдөрлөгийг төрийн болон төрийн бус 7 байгууллагатай хамтран зохион байгуулж 730 гаруй залуучуудыг хамруулсан. Үүнд: Монголын аялал жуулчлалын холбоотой хамтран нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын "100 хөтөч" бэлтгэх сургалтад 100 залуу, аймгийн Политехникийн коллежтой хамтран "Эсгий урлал"-ын сургалтад 30 залуу, "Бидний бахархал" төслийн зохицуулагч Х.Эрдэнэпил болон АЗДТГ-ын Цэргийн штабын хэлтэстэй хамтран "Эх оронч 10000" сургалтад 250 ахлах ангийн суралцагчид , Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар болон Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 5 компанитай хамтран залуу төрийн албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор "Залуучуудыг чадавхжуулах сургалт, зөвлөгөөн"-ий үеэр "Хувь хүний хөгжил, манлайлал", "ICO чанарын менежмент", "Ажил амьдралын тэнцвэрт байдал" сэдэвт сургалтад 270 залуу, Өлзийт тосгоноос хамтран зохион байгуулсан "Аз жаргалтай гэр бүлийн 4 нууц" сэдэвт сургалтад 25 гэр бүл, Хэрлэн сумын ЗДТГ-аас залуу малчдад зориулсан сургалтад 30 залуу өрхийг хамруулсан байна.	10	Орон нутгийн төсөв
--	--	---	--	------------	------------	--	-----------	---------------------------

		2.1.2.3. Бүс, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, инновацад суурилсан гарааны бизнесийн хөрөнгө оруулалт, санхүүжилт /гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын сан, санхүүгийн дэмжлэгийн хөтөлбөр/-ийн орчныг сайжруулна.	228. Орон нутгийн хөгжил, бодлого, онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих халамжаас хөдөлмөрт шилжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх	100%	100%	Инноваци шингэсэн шинэлэг санал санаа, залуу гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих, бүтээлч төслүүдийг олон нийтэд таниулах, дэмжих зорилгоор 2025.05.19-ны өдөр Зүүн бүсийн залуучуудын дунд зохион байгуулагдсан "Start Up Demo Day-25" арга хэмжээний "Start up weekend" 3 хоногийн сургалтад 3 баг оролцож, 2025.06.20-ны өдөр Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын "Амиго" сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3 дугаар байранд орж 15,0 сая төгрөгийн 50 хувийн эргэн төлөлттэй санхүүжилтийг авсан.Аймгийн хэмжээнд Шилдэг старт- Апп 2 багийг шалгаруулж, 50%-н эргэн төлөлттэй 30,000,000 төгрөгийн санхүүжилт олгон ажилласан. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэх , аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох дэмжих зорилгоор 5 удаагийн сургалтаар 78 иргэнийг Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалт болон хөдөлмөрт бэлтгэх суурь ур чадварын сургалтад хамруулан 43 иргэнийг байнгын болон түр ажлын ажлын байранд зуучилсан. Мөн мод арчлах,ургуулах арга хэмжээнд Хэрлэн, Батноров, Жаргалтхаан сум, Өлзийт тосгоны зорилтот бүлгийн 74 иргэнийг түр ажлын байранд зуучлан 35,472.000 төгрөгийг зарцуулсан. Зорилтот бүлгийн иргэдийг ажлын байраар хангаснаар хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63,4 буюу 0,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	53	Орон нутгийн төсөв
2.1.2. эрхлэлт	Хөдөлмөр	2.1.2.8. Олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгоно.	238. Эдийн засгийн салбар, хүн амын бүлгээр төрөлжсөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөдөлмөр зуучлалын байгууллагыг ажиллуулах	100%	100%	2025 оны 03 сард ХХҮЕГ-т "JOB CENTER төв байгуулах хүсэлтийг явуулж, Улсын хэмжээнд байгуулагдах эхний 10 аймаг дүүргийн нэгээр сонгогдож "JOB CENTER" төв байгуулах байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, тус төвд ажиллах 2 ажилтныг сонгон шалгаруулж 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр байгуулагдсан.	15	Орон нутгийн төсөв
			240. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, салбар төвүүдийг өргөжүүлж хүртээмжийг нэмэгдүүлэх	100%	100%	JOB CENTER төв нь ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээг 316 иргэнд, бүлгийн сургалтыг 135 иргэнд, 316 ажил хайгч иргэний хөдөлмөр эрхлэх ур чадварт үнэлгээ хийж 45 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан байна.	14.3	Орон нутгийн төсөв

		2.1.2.10. Тогтвортой ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг татвар, эдийн засгийн бодлогоор дэмжинэ.	245. Орон нутагт ахуйн үйлчилгээний цэгийг байгуулах	100%	100%	Хоршоодыг хөнгөлөлттэй зээлд хамруулах Хоршоодоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас 9 сумын 24 хоршоонд 1333.5 сая төгрөгийн зээлийг олгож 24 ажлын байр хадгалагдаж шинээр 30 ажлын байр бий болгоод байна. Үүнээс 2 хоршоонд 128.3 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг ахуйн үйлчилгээний чиглэлээр олгосон. Төр, хувийн хэвшлийн хүрээнд 2025 онд шинээр 10 ахуйн үйлчилгээний салбар шинээр байгуулагдсан. Үүнд: - Жаргалтхаан сумын "Нутгийн тал" ХХК, нийтийн халуун ус, хувцас угаалга - Баянмөнх сум - Хувцас угаалга - Мөрөн сум "Элит эко" жуулчны бааз-Саун душ - Хэрлэн сум "Gut laundry" ХХК-нь өөртөө үйлчлэх хувцас угаалгын газар - Эвт худалдааны төвийн үйлчилгээний өргөтгөл - Хивс угаалгын газар - Найман шарга төвд үсчин, манюкур - Хан номадс зочид буудал - Хэрлэн сумын Баянмөнх, Булаг багт авто угаалгын 2 төв - Мөнхшувуут ХХК гоо сайхны салон тус тус шинээр үйл ажиллагаа явуулж, нийт 27 ажлын байр шинээр бий болсон.	0	Холимог эх үүсвэр
		2.1.3.8. Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.	261. Бага орлоготой өрхийн тогтвортой амьжиргааг дэмжих урт хугацааны хөтөлбөрийг аймаг, дүүрэгт туршилтаар хэрэгжүүлэх	100%	100%	Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулах зорилгоор нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэх , аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох дэмжих зорилгоор 5 удаагийн сургалтаар 78 иргэнийг Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалт болон хөдөлмөрт бэлтгэх суурь ур чадварын сургалтад хамруулан 43 иргэнийг байнгын болон түр ажлын ажлын байранд зуучилсан.Мөн мод арчлах,ургуулах арга хэмжээнд Хэрлэн, Батноров, Жаргалтхаан сум, Өлзийт тосгоны зорилтот бүлгийн 74 иргэнийг түр ажлын байранд зуучлан 35,472.000 төгрөгийг зарцуулсан.	35.47	Орон нутгийн төсөв

	2.2.1. Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол	2.2.1.4. Боловсролд бүх хүүхэд, залуучуудыг тэгш хамруулах зарчмыг баримталж, ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудыг хамруулсан, тэдний гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцсэн, тохируулгат орчин, дэд бүтэцтэй, хувилбартай, гэрийн сургалттай боловсролын үйлчилгээг бүх түвшинд бий болгоно.	308. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн, хувилбарт сургалтад хамруулах	90%	90%	Хэнтий аймагт нийт 7 сургууль ганцаарчилсан сургалт явуулдаг. Эдгээр сургуулийн 17 ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хөндлөнгийн үнэлгээ хийхэд 78 хувийн гүйцэтгэлтэй байна. Сургууль завсардалтын талаар тандалт судалгаа хийх явцад Батноров ЕБС, Бэрх ЕБС-ийн хичээлдээ явахгүй байгаа 5 суралцагчийг илрүүлж, нэн шаардлагатай 2 суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчтай уулзалт зохион байгуулж зөвлөгөө өгч, 3 суралцагчийн мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисст мэдээлж кейс хэлэлцүүлэн холбогдох арга хэмжээг авч үүний үр дүнд эдгээр 5 суралцагч хичээл завсардалтгүй болсон. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд тохирох сургалтын хэрэглэгдэхүүний судалгааг гарган судалгаанд үндэслэн сургуулиудад чиглэл өгч 8 сургууль 5,960,500 мянган төгрөгийн хэрэглэгдэхүүнийг худалдан авч хичээл сургалтын үйл ажиллагаанд хэрэглэж байна. 2025-2026 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд ялгаатай хэрэгцээтэй цэцэрлэгийн насны 54 хүүхдээс 46 хүүхэд нь цэцэрлэгт хамрагдаж байна. Хамрагдалтын хувь 85,1%, ЕБС-ийн насны 190 хүүхдээс 165 хүүхэд нь сургуульд хамрагдаж байна. Хамрагдалтын нийт хувь 86,8%-тай байна. Сургууль цэцэрлэгт хамрагдаагүй үлдсэн 13.2 хувь нь 4 мөчний саажилт, 2 нүдний хараагүй, тархины саажилт, аутизмын хүнд хэлбэр, эцэг эхийн хандлага, бусад хавсарсан шалтгаанаар хувилбарт сургалтад хамрагдах боломжгүй байна.	292.8	Улсын төсөв
			309. Малчдын хүүхэд, малчин залуучуудын боловсролыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх	90%	90%	Аймгийн хэмжээнд 2025-2026 оны хичээлийн жилд ЕБС-д 17677 суралцагч суралцаж байгаагаас 5979 суралцагч хүүхэд малчдын хүүхэд байна. Үүнээс бага боловсролд 2775, суурь боловсролд 2193, бүрэн дунд боловсролд 101 суралцагч, СӨБ-д 1426 хүүхэд боловсрол эзэмшиж байна. 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Бор-Өндөр, Дархан, Баянмөнх, Баянхутаг Галшар сумдын 130 малчин өрхийн 15-45 насны 238 малчин залуучуудад цахим ур чадвар, Эрүүл зөв хооллолт, "Ухаалаг хашаа, Усалгаа, аж ахуйн хяналтын систем"-н талаар сургалт хийгдэж, Галшар, Өмнөдэлгэр суманд "Малчид, хоршоологчдын" зөвлөгөөн-2025 ХХААГ болон Насан туршийн сургалтын төв, НДГ, Татвар, МИГ даатгал, ГХБХБГ хамтран малчдад энтрепренер сургалтыг олгосон зөвлөгөөн хийгдсэн.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй

	2.2.4. Цахимжсан боловсрол	2.2.4.3. Иргэдэд насан туршдаа суралцах тэгш боломжийг бүрдүүлж, нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, хүн бүрд орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах, боловсрол эзэмших тэгш хүртээмжтэй сургалтын контент, мэдээллийн системийг нэвтрүүлж, ур чадвар, чадамжийг дэмжсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, гэрчилгээ олгох, микро кредитийн сургалтыг холбогдох талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	383. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүл, иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, энэ чиглэлээр хот, аймаг, сум, дүүрэг, хороо, байгууллагыг дэмжих, сургах	90%	90%	Боловсролын байгууллагын бодлого үйл ажиллагааг эцэг эх асран хамгаалагчдад таниулах, хамтын ажиллагааг сайжруулж боловсролын байгууллагын эерэг хандлагыг нэмэгдүүлэх, зорилгоор ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт гэр бүлийн дэмжлэгийн 14 хоног "Ирээдүйн иргэдийн төлөө хамтдаа" өдөрлөгийг 2025 оны 03-04 дүгээр сард зохион байгуулсан. Уг арга хэмжээ 7 чиглэлийн хүрээнд явагдсан ба боловсролын салбарын бодлого чиглэл, сургууль, цэцэрлэгийн менежментийг сайжруулах чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлын талаарх мэдээлэл тавьж цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагчийн санал бодлыг сонссон ба тус арга хэмжээнд ЕБС-ийн 9463, цэцэрлэгийн 4356 эцэг эх асран хамгаалагч хамрагдлаа. "Гэрэлт ирээдүйн төлөө хамтдаа" гэсэн уриалгыг сум орон нутгийн удирдлага, багш, ажилтан, иргэд олон нийтийн дунд 09 дүгээр сард дэвшүүлж, боловсролын 2025-2026 оны хичээлийн жилийн зорилго болон хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр цахим, танхим хосолсон сургалт, мэдээлэл, хурал зөвлөгөөнийг давхардсан тоогоор 23541 хүнд хүргэн ажиллалаа.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
--	----------------------------	---	--	-----	-----	--	---	-----------------------------------

	2.3.1. Нийгмийн эрүүл	2.3.1.1. Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	387. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлж, идэвхжүүлэх	90%	90%	2025 оны 11 сарын байдлаар эрүүл мэндийн салбарт ОНХ-аар 5 төрлийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд нийт 160,000,000 төгрөг шийдвэрлэж дэмжлэг үзүүлсэн бөгөөд үүнд “Эх хүүхдийн эрүүл мэнд, эрт илрүүлэг” хөтөлбөрт 40,000,000 төгрөг, Хэрлэн сумын иргэдийн сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийн зардалд 2,000,000 төгрөг, "Хавдрын эсрэг хамтдаа" арга хэмжээний эрт илрүүлэг, оношлуур, тоног төхөөрөмж, сургалтын үйл ажиллагааны зардалд 80,000,000 төгрөг, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд 5,000,000 төгрөг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэгийг дэмжих, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, зонхилон тохиолдох өвчлөлөөс сэргийлэхэд 35,000,000 төгрөг тус тус зарцуулсан. Үүний үр дүнд артери гипертензийн эрт илрүүлэг үзлэгт нийт 31,863 хүн буюу хамрагдах хүн амын 64.3 хувь нь хамрагдаж, үүнээс 165 тохиолдолд онош батлагдсан бол чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-аас дээш насны 29,529 хүн буюу 91.3 хувь хамрагдаж, үүнээс 56 тохиолдолд онош батлагдсан; мөн хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт зорилтот насны 12,038 хүн буюу 75.6 хувь, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт 1,732 хүн буюу 41.5 хувь хамрагдаж, хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг 112 тохиолдол илэрч, үүнээс 9 нь шинэ хорт хавдрын тохиолдол, ПАП шинжилгээгээр 8.9 хувь нь эсийн түвшний өөрчлөлттэй байсны дунд 14 шинэ хорт хавдрын тохиолдол бүртгэгдсэн.	160	Орон нутгийн төсөв
--	-----------------------	---	---	-----	-----	---	-----	--------------------

	мэнд	2.3.1.2. Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, эрүүл мэндэд эрсдэл үүсгэж байгаа хүчин зүйлс, архи, тамхины хэрэглээг бууруулж, гар утсанд суурилсан стратегийн тусламжтайгаар иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг дэмжинэ.	394. "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах" арга хэмжээ хэрэгжүүлэх	90%	90%	Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 11 сарын байдлаар 679 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 85,7 ногдож байна. Улсын дундаж 132.1 улс аймгийн дунджаас доогуур байна. Нийт халдварт дотор Салхинцэцэг /256/37,7 хувь, Улаан бурхан /188/27,6, БЗДХ /114/ 16,8 хувь, хоолны хордлого /59/8,7 хувь, сүрьеэ /39/ 5,7 хувь тус тус бүртгэгдсэн байна. 2025 оны 03 дугаар сараас 12 дугаар сарын байдлаар Улаанбурхан өвчний 205 тохиолдол бүртгэгдсэнээс 136 (66.3%) тохиолдлыг лабораториор, 69 (36.5%) тохиолдлыг эмнэлзүйн оношоор баталгаажуулсан. Хавьтлаар тогтоосон 1172 хавьтлын 574 иргэнийг голомтын дархлаажуулалтад хамруулж аймгийн хэмжээнд голомтын үеийн хариу арга хэмжээг 91.3%-тай авч хэрэгжүүлсэн. Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний 35 удаагийн сургалтыг ЭМБ-ын 57 эмч, ажилчдад 7 хоног бүрийн 2 дах өдөр цахимаар зохион байгуулсан. 2025 оны эхний 10 сарын байдлаар “Осол гэмтлээс сэргийлэх 0-5 насны хүүхдийн аюулгүй орчин” сарын аян, “Хорт хавдрын эсрэг анхаарал хандуулах сарын аян”, “Дэлхийн тамхигүй өдөр” аян, Тамхигүй ирээдүй сарын аян, Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх, нөхөн дархлаажуулалтын ач холбогдол зэрэг арга хэмжээний хүрээнд 13 сэдвээр Эрүүл мэндийн газраас иргэдэд 63, Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас иргэдэд 201 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулан, зорилтот бүлгийн 36% буюу насанд хүрсэн 5065 иргэд олон нийт, өсвөр насны 4020 хүүхдүүдэд эрүүл мэндийн	5	Орон нутгийн төсөв
	2.3.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж	2.3.2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, орон нутгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, зарим тусламж, үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулна. /Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төв-II, Халдварт өвчин судлалын үндэсний төв-II, Зүрх судасны үндэсний төв/.	401. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх	90%	90%	Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах зорилготой Эрүүл мэндийн сайдын тушаалаар томилогдсон Үндэсний багийн 8 гишүүн 2025 онд нэг удаа ирж ажилласан. Энэ хугацаанд ангиографын оношилгоог 22 иргэнд, зүрхний үзлэгийг 61, хавдрын үзлэг, оношилгоог 80 иргэнд хийж зөвлөгөө өгсөн. Мөн нэгдсэн эмнэлгийн холбогдох эмч, мэргэжилтнүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлж ажлын байрны дадлага, сургалтыг хийж ажилласан. Ангиографын оношилгоо, эмчилгээг нутагшуулах зорилгоор УХТЭ-ийн эмч нартай хамтран ажиллаж байна. Мөн орон нутагтаа хавдрын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хими эмчилгээг нутагшуулах зорилгоор ХСҮТ-тэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний хэрэгжилтийн хүрээнд хавдрын хими эмчилгээний эмч, сувилагч, эмч зүйч нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулан эмчилгээг эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	0	Улсын төсөв

2.4. Баялагтаа эзэн монгол хүн									
	2.4.1. баялгийн төлбөрийн нийцсэн сууцжуулалт	Үндэсний сан, чадварт орон	2.4.1.6. Эх үүсвэрээ бие даасан болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлнэ.	442. Амины орон сууцны технологи дамжуулах төв байгуулах	90%	90%	2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр ногоон, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барихад иргэдийг мэдээллээр хангах зорилготой өдөрлөгийг АЗДТГазар, ХСЗДТГазар, Хас банк, Төрийн банктай хамтран зохион байгуулж эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц, ногоон барилга барих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 7 аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжиж танилцуулга мэдээллийг иргэдэд өгч, ногоон технологийн талаар сургалт хийж 128 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. Мөн энэ үеэр "ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ХУВИЙН ОРОН СУУЦ"-ны нэг маягийн зураг төсөл /44м2-Термоблокон ханатай хувилбар/, “Амины орон сууцны мэдээллийн төв”-ийн үйл ажиллагааны хүрээнд 40м2, 60м2, 80м2, 100м2, 120м2 хүртэл сонголтой хийгдсэн амины орон сууцны зураг төслүүдийг танилцуулж ажилласан.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
			2.4.3.4. Орон сууц, нийтийн аж ахуйн инженерийн шугам сүлжээ,	460. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу ус хангамж, ариутгах татуургын инженерийн шугам сүлжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх	90%	90%	Тус ажлын хүрээнд Чингис хотын бохир усны төв коллекторын шугамын шинэчлэл, өргөх станц /Хэрлэн сум/-ын ажлын гүйцэтгэл 90 хувьтай хийгдэж байна. Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хэрлэн сум, 1, 2, 3, 4, 5 дугаар баг/ төсөл арга хэмжээний 1-р багийн ажлыг байнгын ашиглалтад оруулсан. 2-р багийн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Айлуудын газартай трасс давхацсаны улмаас ажил удааширсан. 3-р багийн ажил 85%-ийн гүйцэтгэлтэй. 4, 5-р багийн багц ажил 55%-ийн гүйцэтгэлтэй, зуухны каркасны ажил, бохирын ажил хийгдэж дууссан. Дулаан цэвэр усны шугамын худаг цутгах ажлууд хийгдээд байна. Сумын төвийн төвлөрсөн дулаан хангамж, цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээний их засвар /Хэнтий, Бор-Өндөр сум/ төсөл арга хэмжээ 100% хэрэгжиж дууссан. Ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж /Өмнөдэлгэр сум/ төсөл арга хэмжээ 70%-ийн гүйцэтгэлтэй. Ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, цэвэр усан хангамж, усан сангийн байгууламж /Жаргалтхаан сум/ төсөл арга хэмжээ 100% дуусч байнгын ашиглалтад оруулсан. Дээрх 7 төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэл 85% бөгөөд тус оны санхүүжилтэд тусгагдсан гүйцэтгэлийг давуулан биелүүлсэн хувьтай байна.	24391.2	Улсын төсөв

	2.4.3. Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтэц	барилга байгууламжийг өргөтгөн шинэчлэх, дэвшилтэт техник, тоног төхөөрөмж суурилуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, ашиглалтын түвшнийг сайжруулна.	463. Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	90%	90%	Ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж /Өмнөдэлгэр сум/ төсөл арга хэмжээ бодит гүйцэтгэл 70%, тус оны санхүүжилтэд тусгагдсан гүйцэтгэлийг 100% биелүүлсэн. Ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, цэвэр усан хангамж, усан сангийн байгууламж /Жаргалтхаан сум/ төсөл арга хэмжээ 100% дуусаж байнгын ашиглалтад оруулсан.	1682.2	Улсын төсөв
			464. "Орон нутгийн хөгжлийн төв"-ийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	90%	90%	ХББОСЯамнаас хэрэгжүүлж буй "Төрийн албан хаагчдын орон сууцны цогц хөтөлбөр"-т Жаргалтхаан суманд Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууц, Хэрлэн, Биндэр суманд Төрийн албан хаагчдын 15 айлын орон сууц баригдахаар 3 сум хамрагдаж төсөв батлагдан хэрэгжиж эхлээд байна. Жаргалтхаан сумын Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны барилга угсралтын ажил 3-р улиралд эхэлсэн гүйцэтгэлийн хувь 45%, Хэрлэн, Биндэр сумын Төрийн албан хаагчдын 15 айлын орон сууцны төслийн гүйцэтгэгч барилгын зураг төслийн ажлыг гүйцэтгэж дууссан. Хэнтий аймаг нь 12 суманд ариутгах татуурга шугам сүлжээ, ус хангамж, цэвэрлэх байгууламжийн ажил хийгдсэн орон сууц, үйлчилгээний барилга байгууламж, барих бүрэн боломжтой, 2 суманд тус ажил нь үргэлжилж байна. Мөн Цэвэрлэх байгууламж бүхий 12 сумын төрийн байгууллагуудыг төвийн инженерийн шугам сүлжээнд холбуулах ажлыг үе шаттай зохион байгуулж эхний ээлжид "Сумдын төрийн байгууллагуудыг ИШС-нд холбох ажил /Баян-Адарга, Дадал, Норовлин, Батноров, Баян-Овоо, Цэнхэрмандал/ төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 100% хэрэгжүүлж дууссан.	400.08	Улсын төсөв

		2.4.3.7. Бохирдуулагч үйлдвэр, үйлчилгээний салбарын хаягдал усны хяналтыг сайжруулна.	468. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын урьдчилан цэвэрлэх байгууламж болон ахуйн бохир усны бага хүч чадлын цэвэрлэх байгууламжаас гарч байгаа хаягдал усны стандартын шаардлагыг хангуулах, хяналт шалгалт хийх	100%	100%	Аймгийн хэмжээнд хяналт шалгалт зохион байгуулан, бохирдуулагчдын судалгааг шинэчлэн гаргаж, 236 аж ахуйн нэгж байгууллагад 35,304,526 төгрөгийн ус бохирдуулсны төлбөр ноогдуулж, 68 байгууллагыг ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу төлбөрөөс чөлөөлсөн. 2025 онд нийт 49 аж ахуйн нэгжид ус бохирдуулах дүгнэлт, Бор-Өндөр суманд уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлд 2412.6мян/м3, Хэрлэн суманд эрчимжсэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд 4.0мян/м3 технологийн саарал усыг эргүүлэн ашиглах дүгнэлт гаргасан. Ашиглалтад орсон 12 сумын цэвэрлэх байгууламжаас гарч байгаа саарал усыг шинжилгээнд хамруулахад 95-98 хувийг цэвэршүүлсэн буюу хаягдал усны стандартын шаардлагыг хангасан түвшинд байна. Чингис хотын Цэвэрлэх байгууламж нь саарал усны шинжилгээг долоо хоног бүр тогтмол хийж, 86–93 хувь хүртэлх түвшинд цэвэршүүлж буй шинжилгээний хариу гарсан бөгөөд тогтмол хяналттайгаар ажиллаж байна.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО								
3.3. Эдийн засгийн төрөлжилт, либералчлал								
3.3.1. Уул уурхай	3.3.1.7. Газрын ховор элемент боловсруулах үйлдвэрийн төслүүдийг бодлогоор дэмжинэ.	579. Газрын ховор элементийн ордын нөөцийг өсгөх, төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ, зураг төсөл боловсруулах	90%	90%	Бор-Өндөр сумын ойр орчмын бүс нутгийн ашигт малтмалын нөөц боломж, дэд бүтэц, өнөөгийн Бор-Өндөр УБҮ-ийн нөөц бололцоо зэрэгт үндэслэн Жонш, төмрийн баяжмал, Фторт хөнгөн цагаан, Төмөр цахиурын хайлш, Хагас коксын боловсруулах үйлдвэрүүд бүхий Бор-Өндөр үйлдвэрлэл, технологийн паркийн төслийг дэмжиж, Бор-Өндөр суманд 787 га газрыг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Газрын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжуудад нийцүүлэн улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, дэмжсэн санал бүхий тогтоолыг ЗГХЭГ болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлсэн. Төслийн хэрэгжүүлэгч "Эрдэнэс Монгол УТП" ХХК-д Үйлдвэрлэл, технологийн паркийн тусгай зөвшөөрөл авах саналыг мөн дэмжиж АҮЭБЯаманд уламжилсан. Дээрх асуудлууд шийдэгдсэнээр төслийн дэд бүтэц, барилга байгууламжийг барих ажлын болон үндсэн үйлдвэрүүдийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулагдаж, хөрөнгө оруулалтын загвар тодорхойлогдоод байгаа бөгөөд төслийн хамгийн гол бичиг баримт болох 2035 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл бэлэн болсон байна.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй	

			726. 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв барих төслийг хэрэгжүүлэх	100%	70%	Дулааны станцын барилгын ажлыг үндсэн гүйцэтгэгч БНСУ-ын "Бьюксан инженеринг" компани, туслан гүйцэтгэгчээр "Хасу мегаватт" компани гүйцэтгэж байгаа бөгөөд зуух угсралтын ажил 60%, халах гадаргуугийн ажил 85%, барилга угсралтын ажил 45%-тай түр зогсолт хийсэн байна. Дулааны станцын 2-р хэлхээ ДДТ-үүдийн Дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл арга хэмжээ нь 2025 оны санхүүжилтэд тусгагдсан ажлаа 100% хийж гүйцэтгэсэн. 2025 оны 09 дүгээр сарын 13-ний өдөр ажлын талбайд 10 аймгийн дулааны станц барих төсөл, Солонгос, Монгол гүйцэтгэгч, БНСУ-ын Эксим банк, Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төв, аймгийн ГХБХБГ хамтарсан үзлэг шалгалт хэрэгжүүлэн үлдэгдэл ажлын тоо хэмжээг тулгаж ажиллалаа.	38500	Гадаадын зээл тусламж
	3.3.3. Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал		727. Дулааны станцын дэд бүтцийг байгуулах, дулаан түгээх сүлжээг шинэчлэх буюу шинээр барих	100%	70%	Дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл арга хэмжээ нь 3 багцад задарч тендер зарлагдсан. Багц-2 Дэд бүтэц /Усан хангамж, ариутгах татуурга/ төсөл арга хэмжээний хүрээнд 600м бохир, 700м цэвэр усны шугамын ажил хийгдэж тус оны санхүүжилтэд тусгагдсан ажлаа 100% хийж гүйцэтгэсэн. Багц-1 Цахилгаан хангамж /Дулааны станц, дулаан дамжуулах төв/ болон Багц-3 Холбоо мэдээлэл /Дулааны станц, дулаан дамжуулах төв/ төсөл, арга хэмжээнүүд 100% хэрэгжиж дууссан. Улсын комисс ажиллуулахад бэлэн болоод байна.	3174	Улсын төсөв
		3.3.3.37. Аймгуудын төв болон сум, суурин газруудын дулаан хангамжийн дэд бүтцийг сайжруулах, үр ашиг өндөртэй нүүрс, сэргээгдэх эрчим хүчний технологийг ашигласан станцуудыг байгуулах суурь судалгааг хийж, төслүүдийг эхлүүлнэ.	753. Аймгийн төв, сум, суурин газрын дулааны эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, дулааны шугам сүлжээг шинэчлэн сайжруулах, дулааны алдагдлыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх	90%	90%	2025 оны аймгийн ОНХСангийн 150сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам засвар, шинэчлэл - 4 дүгээр ээлжийн ажлын зураг, төслийн гүйцэтгэгчээр "Анга трасс" ХХК шалгаран 2-р улиралд зураг төслийг 100% дуусгаж хүлээлгэн өгсөн. Тус Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам засвар, шинэчлэл - 4 дүгээр ээлж ажил нь Эрчим хүчний сайдын багцад 15.4 тэрбум төгрөгийн төсөвтэй батлагдаж тендер 3 удаа зарлагдаж, гүйцэтгэгчээр "Баткомплект" ХХК шалгарч 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдөр гэрээ байгуулсан. Мөн Биндэр сумын төвийн зуухны хүчин чадал нэмэгдүүлэх ажлын тоног төхөөрөмжийн татан авалт 100% хийгдсэн.	150	Орон нутгийн төсөв

		3.3.4.8. Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулж, өвс, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр хувийн хэвшилтэй хамтран ажиллана.	782. Тэжээлийн үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтыг сайжруулах, өргөтгөх, агуулах, саравч байгуулах /Нийт тэжээлийн үйлдвэрийн суурилагдсан хүчин чадлын 80 хувийг ашиглах/	70%	70%	Энэ онд тэжээлийн таримлыг нэмэгдүүлэх зорилгоор тус аймагт 4 төрлийн 11.2 тн буюу 53.0 сая төгрөгийн тэжээлийн үрийг ХХААХҮЯамнаас хуваарилж, Өлзийт тосгоны "Эй, Эс поржект" ХХК-д хошуу будааны 7 тн үрийг 2 жилийн хугацаатай зээлийн гэрээ байгуулж олгосон. Үлдсэн 4.2 тн тэжээлийн үрийг ирэх хаврын тариалалтад нөөцөлсөн. Аймгийн хэмжээнд энэ онд 9 сумын 15 иргэн, 14 аж ахуйн нэгж, 2 хоршоо 6277 га-д ногоон тэжээл тариалж, 19760 тн ургац хураан авсан. Мөн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор 15 сумын өвс, тэжээлийн агуулахад 1683.5 тн өвс, 917.4 тн тэжээл нөөцөлж, сумын аюулгүй нөөцийг бүрдүүлээд байна. Энэ онд Малын тоо, толгойн албан татварын орлогоос өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэхэд 4 сум 124.0 сая, малын тэжээлийн ургамал тариалахад 2 сум 14.7 сая нийт 138.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Аймгийн аюулгүйн нөөцийн өвс тэжээлийн агуулах, саравчны хүчин чадал, аюулгүй байдал, ашиглалтыг сайжруулах зорилгоор иж бүрэн засварлах ажлын зураг төсвийг "Уран тод цэг" ХХК-тай гэрээ байгуулж хийлгэж байна. 2026 оны ОНТ-т засварын ажлын төсвийг тусгаж батлуулсан.	138.7	Орон нутгийн төсөв
		3.3.4.11. Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлж, малын генийн санг хамгаалж, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ.	787. Малын генийн сан бүрдүүлэх биотехнологийн төв, түүхий эдийн анхан шатны чанарын лабораторийг бүсчлэн байгуулах	70%	70%	Аймгийн хэмжээнд 6 сумын 1 аж ахуйн нэгж, 8 өрхөд сүүний чиглэлийн 180 үхэр, 5 сумын 4 аж ахуйн нэгж, 8 өрхөд махны чиглэлийн 5253 үхэр, 7 сумын 7 аж ахуйн нэгж, 106 өрхөд мах-сүүний хосолмол ашиг шимтэй 8533 үхэр, 1 сумын 1 аж ахуйн нэгжид нарийн, нарийвтар ноосны чиглэлийн 280 толгой хонь, 5 сумын 1 аж ахуйн нэгж, 5 өрхөд бүдүүн, бүдүүвтэр ноосны чиглэлийн 1250 толгой хонь, 7 сумын 65 өрхөд хурдны чиглэлийн 222 адуу тус тус үржүүлэгдэж байна. Өндөр ашиг шимт малын тоо толгойг нэмэгдүүлэх, үржүүлэг, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх хүрээнд ОНТ-ийн 133.4 сая төгрөгийн хөрөнгөөр Норовлин, Хэрлэн сумдын 5 өрхийн 1112 үнээнд Герефорд, Ангус, үүлдрийн бухын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн. Малын удмын сангийн үндэсний төвийн Хэнтий аймаг дахь салбар нэгжийн цөм сүрэг тал нутгийн цагаан үүлдрийн 100 толгой хонинд дурангийн аргаар Австралийн меринос хонины гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн.	133.4	Орон нутгийн төсөв

		3.3.4.13. Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг хангах зорилгоор "Атар IV" аяныг хэрэгжүүлж, газар тариалангийн нийт эргэлтийн талбайг 200 мянган га-аар нэмэгдүүлнэ.	803. Жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн газруудыг орон нутагт байгуулах	100%	100%	2024 онд улсын төсвийн 240.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн суманд 3га газарт "Жимс, жимсгэний суулгац үржүүлгийн төв" байгуулагдсан. 2025 онд жимс, жимсгэнэ 55.8 га-д тариалж 15.2 тн ургац хураан авсан. Шинээр Дархан, Биндэр, Дадал, Норовлин, Хэрлэн, Бор-Өндөр сумд 5 төрлийн жимс, жимсгэнийн суулгацыг 3.2 га-д тариалсан.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
3.3.4. Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр			812. Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, гоц халдварт өвчинд өртөх өрхийн эрсдэлийг бууруулах	100%	100%	Гоц халдварт 4 төрлийн өвчний дархлаажуулалтад 6.5 сая мал хамруулж гүйцэтгэл 91.8%-тай хийгдсэн. Дархлаажуулалтын үр дүнд урд онтой харьцуулахад гоц халдварт өвчин 18.1%-р буурсан. Үүнд: Үхрийн арьс товруутах- 4 сумын 92.5 мян.мал хамрагдахаас 88.0 мян.мал хамрагдаж гүйцэтгэл 95.2%-тай, Бог малын мялзан-18 сумын 3900.0 мян.мал хамрагдахаас 3821.9 мян.мал хамрагдаж гүйцэтгэл 97.9%-тай, Хонины цэцэг - 18 сумын 2157.6 мян.мал хамрагдахаас 2129.8 мян.мал хамрагдаж 98.4 %-тай18 сумын 347.1 мян.мал хамрагдахаас 337.7 мян.мал хамрагдаж гүйцэтгэл 97.%-тай, Шүлхий/хавар/-18 сумын 347.1 мян.мал хамрагдахаас 337.7мян.мал хамрагдаж 97.3%-тай хийгдэж дууссан. Шүлхий/намар/-18 сумын 458.7 мян.үхэр, 0.873 гахай, 56.9 мян.бог мал, амьтан хамрагдахаас 153.1 мян.мал үхэр 33.3%-тай, бог 37.3 мян.мал хамрагдаж 65.5%-тай тус тус үргэлжилж байна.	793.1	Холимог эх үүсвэр
		3.3.4.16. Экспортын түүхий махны мал эмнэлэг, хорио цээрийн олон улсын шаардлагыг хангасан	813. Зонхилон тохиолддог өвөрмөц урьдчилан сэргийлэх арга хэмжээ бүхий халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах замаар халдварт өвчний тоог бууруулах	100%	100%	Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 17-ний А/212 тоот захирамжийн дагуу Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 549.5 мянган мал хамруулсан. Үүнд: -Дуут: 18 сумын 85.6 мян.мал хамрагдахаас 85.1 мян.мал хамрагдаж гүйцэтгэл 99.4%-тай, -Дотрын халдварт хордлого: 18 сумын 300.мян.мал хамрагдахаас 292.2 мян.мал хамрагдаж гүйцэтгэл 97.4%-тай -Цусан халдвар: 18 сумын 172.0 мян.мал хамрагдахаас 171.1 мян.мал хамрагдаж гүйцэтгэл 99.4%-тай, -Гахайн цусан халдвар: 4 сумын 2.0 мян.мал хамрагдахаас 1.9 мян.мал хамрагдаж гүйцэтгэл 97.8%-тай тус тус хийгдсэн.	97	Орон нутгийн төсөв

	улсын шаардлагыг хангасан "Монгол мах" брэндийг хөгжүүлж, махны үнийг зах зээлийн зарчимд шилжүүлнэ.	814. Тэргүүлэх чиглэлийн зооноз өвчнөөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, халдварт өвчний тохиолдлыг бууруулах	100%	100%	Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний А/23 тоот захирамжийн дагуу галзуу, боом, листериоз, бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 429.1 мянган мал хамруулсан. Үүнд: -Галзуу: 15 сумын 99.1 мян.мал хамрагдахаас 97.9 мян.мал хамрагдаж гүйцэтгэл 99.9%-тай, -Боом: 14 сумын 242.6 мян.мал хамрагдахаас 243.2 мян.мал хамрагдаж гүйцэтгэл 100.2%-тай, -Листериоз: 1 сумын 25.0 мян.мал хамрагдахаас 24.9 мян.мал хамрагдаж гүйцэтгэл 100.2%-тай, -Бруцеллөз: 18 сум 675.5 мян.мал хамрагдахаас 671.9 мян.мал хамрагдаж 99.4 %-тай тус тус хийгдсэн.	103.5	Улсын төсөв
		816. Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг явуулж, мах, махан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах	100%	100%	Аймгийн засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/255 тоот “Мал бэлтгэх, төхөөрөх, мах махан бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалах, экспортлоход тавигдах шаардлагыг хангуулах” тухай захирамжийн хүрээнд Мал эмнэлгийн газар, ХХААГ, ЭМГ, ХХҮГ, БОГ –ын хамтарсан улсын ахлах байцаагчдын баталсан 08-34-02/056/01 удирдамжийн дагуу 5 сумын 15 мал төхөөрөх үйлдвэрт хяналт шалгалтыг зохион байгуулсан ба дараах зөрчил дутагдлыг илрүүлсэн. Үүнд: Сумдын зарим мал төхөөрөх цэг нь аж ахуйн нэгжээр бус иргэнээр бүртгэлтэй, мал төхөөрөх ихэнх үйлдвэр, цэгүүд дотоод хяналтын хэрэгжилт хангалтгүй, мал төхөөрөх үйлдвэр, цэгүүдэд малын эмчийн хүрэлцээ хангалтгүй, мал төхөөрөх үйлдвэр нь лабораторитой байх ба мэргэжлийн мал эмнэлгийн лабораторитой гэрээ байгуулаагүй, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа хангалтгүй хийгддэг зэрэг зөрчлүүд гарч мэргэжил арга зүйн заавар, зөвлөмж өгч мах, махан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авч ажилласан.	7.9	Орон нутгийн төсөв
	3.3.4.21. Бэлчээрийг нөхөн сэргээх, сэлгэх, тарималжуулах, хамгаалах, усжуулах, ургамал хамгааллыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	829. Уст цэг тогтоох хайгуул судалгаа хийж, инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах	100%	100%	Улсын төсвийн 89.7 сая төгрөгийн хөрөнгөөр инженерийн хийцтэй 3 худаг, орон нутгийн төсвийн 249.5 сая төгрөгийн хөрөнгөөр 13 худаг, төсөл хөтөлбөрөөр 101,5 сая төгрөгөөр 6 худаг, малчдын санхүүжилт болон бусад эх үүсвэрийн 58.0 сая төгрөгийн хөрөнгөөр 5 худаг, нийт 498.7 сая төгрөгийн хөрөнгөөр 12 суманд 27 худаг шинээр гаргаж 40.5 мянган га бэлчээрийн талбайг усжуулсан. УТ 89.7, ОНТ 249.5, ТХ 101.5, бусад 58.0	498.7	Орон нутгийн төсөв, Улсын төсөв, Холимог эх үүсвэр

		3.3.5.6. Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдааны сувгуудаар дэмжинэ.	886. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, орлогыг нэмэгдүүлэх	100%	100%	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих, худалдаа, борлуулалтыг нэмэгдүүлэх, нутгийн брэнд бүтээгдэхүүний нэр төрөл, сав баглаа, боодол, чанар хүртээмжийг сайжруулах, хэрэглэгчдэд сурталчлах, түгээх зорилготой улс, аймаг, бүсийн хэмжээний 10 удаагийн үзэсгэлэн худалдаа, нэгдсэн арга хэмжээнд давхардсан тоогоор 417 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулж, 403.0 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. Мөн аймгийн хэмжээнд жил бүр зохион байгуулагддаг "Хэнтийн намрын баяр 2025", "Цагаан сар-Цагаан идээ 2025", "Өвлийн идэш-2025" нэгдсэн үзэсгэлэн арга хэмжээнд давхардсан тоогоор 18 сум, 5 тосгоны үйлдвэрлэл эрхлэгчид 150 аж ахуйн нэгж, 370 иргэн 200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 647.7 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. "Талын түмэн адуу" аялал жуулчлалын эвент арга хэмжээний үеэр үндэсний болон орон нутгийн 43 үйлдвэрлэгч, хүнсний худалдааны 10, хоол үйлдвэрлэлийн 17 иргэн, аж ахуйн нэгж, хоршоо оролцож, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилж ажилласан бөгөөд нийт 74.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн.	17.5	Орон нутгийн төсөв
			887. Аялал жуулчлалын гол замын дагуу амрах өртөө, түр буудаллах үйлчилгээний цогцолборыг байгуулах	30%	30%	Аялал жуулчлалын гол чиглэл, авто замын дагуух 4 цэгийг сонгон газар эзэмшүүлэх ажил хийгдсэн ба түр буудаллах цэгийн зураг төслийн ажлууд хийгдэж дууссан. Мөн Жуулчид олноор төвлөрөх газарт барих үйлчилгээний 4 блок цогцолборын барилгын зураг төслийн ажил ЭЗХЯамны захиалгаар хийгдэж дууссан. Улсын чанартай авто замын дагуу үйлчилгээний цогцолбор болох түр буудаллах цэг байгуулах зорилгоор Баянхутаг сумын жаргалант 1-р багийн нутаг дэвсгэрт тогтоосон газрыг сумын Засаг даргын Тамгын газрын өөрийн эзэмшилд авсан бөгөөд цаашид Асийстант ХХК төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй

	3.3.5. Дөрвөн улирлын аялал жуулчлал	3.3.5.7. Аялал жуулчлалын гол зам дагуу амрах өртөө, түр отоглох цэг, зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулна.	888. Байгаль, түүх, соёлын үзэсгэлэнт газруудад ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэг байгуулах	100%	100%	Дадал суманд нийт 5 отоглох, буудаллах цэг байгуулахаар төлөвлөж, байршлыг тогтоосноос 4 отоглох цэг байгуулагдсан. Яргайт отог нь ТАЖХТөслийн санхүүжилтээр 53.0 сая төгрөг, Өлийн модны хойд тал ОНХС-ын 34.0 сая төгрөг, иргэн Чингис, Оюунбаатар нар нь хувийн хөрөнгө оруулалтаар отголох цэг байгуулсан. Улсын тусгай хамгаалалттай газартай давхацсан тул сумын Засаг даргатай гэрээ байгуулан үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Аялал жуулчлалын гол бүс нутаг болох Дадал суманд аялагчдад зориулсан түр отоглох, хоноглох 5 цэг ажиллаж 10,000 гаруй хүн хүлээж авсан бол Биндэр сумын 2-р багийн нарсан коридорт 2 отоглох цэг ажиллаж 1500 орчим хүн хүлээж авч үйлчилсэн байна. Аймгийн хэмжээнд 7 отоглох цэгт нийт 11500 хүн амарч үйлчлүүлсэн байна.	87	Холимог эх үүсвэр
			889. Гол бүс нутгуудад аялал жуулчлалын цогцолбор байгуулах	90%	90%	Аялал жуулчлалын гол бүс нутаг болох Биндэр суманд байгуулагдсан "Их хуралдай" цогцолбор 100% ашиглалтад орж байнгын үйл ажиллагаа 6 сарын 22-ны өдрөөс эхэлж, иргэд, олон нийтэд үзвэр, үйлчилгээ үзүүлж эхлээд байна. Батноров суманд "Тэнгэрийн андгай" цогцолбор, Бэрх тосгонд "Монголын далд уурхайн музей, аялал жуулчлалын сургалт мэдээллийн төв" 100% ашиглалтад орж иргэдэд тогтмол үйлчилгээ үзүүлж нээлттэй ажиллаж байна. Дадал суманд "Чингис хаан" мэдээллийн төвийн барилгын ажил 80%-тай, Норовлин суманд баригдаж байгаа "Шихихутаг" цогцолборын ажил 88%, Дэлгэрхаан суманд "Монголын нууц товчоо" цогцолборын ажил 85% гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Цогцолборуудын үлдэгдэл санхүүжилт 2026 оны улсын төсөвт суугдсан тул ирэх онд бүрэн ашиглалтад орно. Хэнтий аймаг нь түүхэн аялал жуулчлалыг бүс нутагтаа хөгжүүлэх зорилгоор Биндэр суманд "Их хуралдай" цогцолборыг барьж энэ онд хүлээн авч 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдөр нээлтээ хийж 8000 гаруй иргэдэд үйлчилсэн бол Бэрх хотод шинээр байгуулагдсан "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв"-ийн үйл ажиллагаа жигдэрч 25670 иргэнд үйлчилсэн байна. Мөн Батноров суманд баригдсан "Тэнгэрийн андгай" цогцолбор 100% баригдаж дууссан. Дадал суманд "Чингис хаан" мэдээллийн төвийн барилгын ажил 69%, Норовлин суманд баригдаж байгаа "Шихихутаг" цогцолбор гүйцэтгэл 88%, Дэлгэрхаан суманд "Монголын нууц товчоо" цогцолборын ажил 85%-тай ажлын явц	2847.2	Улсын төсөв

		3.3.5.8. Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэндийг хөгжүүлж, үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлнэ.	891. Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэндийг хөгжүүлэх "Монгол Урлаг - Дэлхийн тайзнаа" цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	100%	100%	Орон нутгийн онцлогт тулгуурлан улирлын хамаарал бүхий дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 2025 онд адал явдалт танин мэдэхүйн чиглэлээр "Тогорууны баяр" арга хэмжээ, Буриад түмний соёлыг сурталчлан таниулах зорилгоор ""Ёохор хатар-2025"" эвент наадам, адуучин залуусын дунд "Галшар адуу"-ны баяр, Монгол хатдын түүхэн гавьяаг таниулах зорилгоор "Монгол хатад" наадам, адуу дагасан соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Талын түмэн адуу" өвлийн эвент зэрэг 5 арга хэмжээг 6, 7, 8, 9, 11 дүгээр саруудад төлөвлөн нийт 40 үйл ажиллагаа зохион байгуулагдаж дотоодын 35800, гадаадын 191 хүнийг хамруулж биелэлтийг 100% ханган ажилласан. Дээрх 5 арга хэмжээг зохион байгуулахад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласнаас аймгийн Засаг даргын 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс нийт 55,0 сая төгрөгийг зарцуулсан.	55	Орон нутгийн төсөв
		3.3.5.10. Говийн бүсийн Марс гарагтай төсөөтэй онцлогийг шинжлэх ухаан, инновац шингэсэн технологиор баяжуулж, байгаль орчинд ээлтэй, дөрвөн улирлын тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	893. Говийн бүсийн Марс гарагт төсөөтэй онцлогийг шинжлэх ухаан, инновац шингэсэн технологиор баяжуулж, байгаль орчинд ээлтэй дөрвөн улирлын тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	Х.Б	Х.Б	Манай аймгийн газрын нутгийн хувьд говийн бүсид хамраахгүй тул хасуулах саналтай.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
	3.3.6. Соёл урлаг, соёлын өв уламжлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл	3.3.6.9. Монгол кино үйлдвэр орчмыг монгол киноны түүх, соёлд тулгуурлан төрөлжүүлж хөгжүүлнэ.	920. "Кино үйлдвэр" орчмын гудамж, талбай, ногоон байгууламжийг тохижуулж, монгол киноны түүх, соёлыг сурталчлах, кино зураг авалтын бодит түүхэн орчныг бий болгох	Х.Б	Х.Б	Нийслэлд хамаарах заалт тул хасуулах саналтай.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй

3.4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт

		3.4.1.1. Байгалийн унаган төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг сайжруулна.	955. Олон талын оролцоотой хамгааллын менежментийг хэрэгжүүлэх, санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлж, үр ашигт байдлыг сайжруулах	100%	100%	Улсын тусгай хамгаалалттай "Хурх хүйтний хөндий"-н БНГазрыг "Зэрлэг амьтан судлах, хамгаалах" төвтэй 2022 онд, Улсын тусгай хамгаалалттай "Тосон хулстай"-н БНГазрыг "Дорнод хамгаалал" ТӨҮГазартай 2025 онд тус тус 10 жилийн хугацаатай менежмент хариуцагчийн гэрээ байгуулан ажиллаж байна. Улсын тусгай хамгаалалттай Дэлгэрхаан уул, Хэрлэн тооно уул, Тосон Хулстай байгалийн нөөц газруудын менежментийн төлөвлөгөөг 10 жилийн хугацаатай боловсруулан БОУАӨСайдаар батлуулсан. Улсын тусгай хамгаалалттай "Хар ямаат"-ын БНГазарт 2 арга хэмжээнд 9.9 сая, Улсын тусгай хамгаалалттай "Өндөрхаан уул"-ын БНГазарт 1 арга хэмжээнд 4.5 сая төгрөгийн хөрөнгийг ОНТ-т тусгуулан батлуулж, хамгааллын менежментийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан. Улсын тусгай хамгаалалттай Хар ямаатын БНГазарт Дэлхийн байгаль хамгаалах сан, Дорнод Монголын хуурай хээрийн төсөлтэй хамтран 42.3 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгож менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан 20 арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн.	56.7	Орон нутгийн төсөв
--	--	---	---	------	------	--	------	--------------------

	3.4.1.2. Биологийн олон янз байдлын алдагдлыг зогсоож, генетик нөөцийг нэмэгдүүлэн тогтвортой ашиглаж, байгалийн нөөцийг хамгаалж, экологи, эдийн засгийн үнэлгээг тогтоон, био аюулгүй байдлыг хангана.	958. Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг амьтан, түүний тархац нутгийг хамгаалах, шилжилт хөдөлгөөн, тоо толгойн хэвийн өсөлтийг дэмжих арга хэмжээ авах	100%	100%	Нэн ховор, ховор, зэрлэг амьтад (Халиун буга, Бор гөрөөс, Аргаль, Цагаан зээр зэрэг)-ын тархац нутгийг хамгаалах, шилжилт хөдөлгөөнд саадгүй байх, идэш тэжээлийн хомсдолоос болон малын гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвөлжилт, хаваржилтын цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан эрсдэлийг бууруулж, тоо толгойн хэвийн өсөлтийг дэмжих чиглэлээр БХНСЗардлын 59.3 сая төгрөгийн хөрөнгөөр биотехникийн арга хэмжээ, 3.0 сая төгрөгийн хөрөнгөөр орон нутгийн иргэд, малчдад мэдээлэл сурталчилгаа өгөх нөлөөллийн арга хэмжээ, 3.0 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн Засаг даргын 2025 оны А/181 дугаар захирамжийн дагуу мал, амьтны сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээг тус тус хэрэгжүүлж ажилласан. Батширээт сум БХНСЗардлын 4.0 сая төгрөгөөр Номгон агнуурын бүс нутгийн агнуурын шувууны нөөцийг тогтоох судалгааг мэргэжлийн байгууллага "Эко-Үйлчилгээ" ТББ-аар шинэчлэн хийлгүүлж БОУАӨЯ-нд батлуулахаар хүргүүлсэн. Баянмөнх, Баян-Овоо, Батширээт сумд БХНСЗардлын 129.0 сая төгрөгийн хөрөнгөөр 190 толгой, Дархан, Бор-Өндөр сумд дүйцүүлэн хамгааллаар аж ахуйн нэгж байгууллагын 107.0 сай төгрөгийн хөрөнгөөр 110 толгой, нийт 300 толгой "Монгол тарвага"-ыг сэргээн нутагшуулсан.	305.3	Холимог эх үүсвэр
		959. Монгол оронд тархсан харь зүйл ургамлын тархац, түрэмгийллийн өнөөгийн төлөв байдлын судалгааг хийж, хамгааллын цогц арга хэмжээ хэрэгжүүлэх	100%	100%	Аймгийн хэмжээний ургамлын тархац, нөөцийн судалгааг 2020 онд Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнгээр хийлгэсэн. Хэнтий аймагт 96 овгийн 433 төрөлд хамаарах 1202 зүйлийн дээд гуурст ургамал байгааг тогтоосон ба үүнд харь зүйл ургамал бүртгэгдээгүй.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй

3.4.1. Биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент	3.4.1.3. Байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлж, байгаль хамгааллын тогтвортой санхүүжилтийн механизмыг бүрдүүлнэ.	962. Байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт байгаль хамгааллын хамтын менежментийг орон нутгийн нөхөрлөлүүдээр дамжуулан хэрэгжүүлэх	100%	100%	Аймгийн хэмжээнд 9 суманд Байгалийн нөөцийн хамтын менежментийн 118 нөхөрлөл байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 81 нөхөрлөл сумын Засаг даргатай гэрээ байгуулж, тодорхой газар нутаг хариуцан байгаль хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлж хамтран ажиллаж байна. Баян-Овоо сумын Хар ямаатын БНГ-ыг сурталчлах ажлын хүрээнд "Тал нутгийн хангайд Буйлс цэцэглэх цагаар" арга хэмжээг зохион байгуулж, Байгалийн нөөцийн хамтын менежментийн 12 нөхөрлөлийн 116 гишүүдийг хамруулан 2000 ширхэг хайлаас модыг хамтран тарьсан. Норовлин суманд хийсэн хяналт шалгалтын хүрээнд тус сумын Хамтын хүч нөхөрлөлийн ахлагч Н.Сүхбаатарыг хяналт шалгалтын ажилд татан оролцуулж хамтарч ажилласан. Ойн газар, Онцгой байдлын газартай хамтран БНХМ-ийн 15 нөхөрлөлийн төлөөллийг ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулсан. Хөвсгөл аймагт зохион байгуулсан "Нөхөрлөл хөгжил" сургалт, үзэсгэлэн арга хэмжээнд 9 сумын БНХМ-ийн нөхөрлөлийн 200 гаруй гишүүдийг ТНС олон улсын байгууллагын дэмжлэгээр оролцуулсан.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
	3.4.1.4. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 8.8 хувьд хүргэнэ.	963. Ойжуулалтын ажлыг хэрэгжүүлэх	100%	100%	Доройтсон ойг нөхөн сэргээх ойжуулалтын ажлыг БХНСЗардлаар Өмнөдэлгэр суманд 20 га, Дадал суманд 20 га, Батширээт суманд 15 га, Норовлин суманд 1.0 га, нийт 56 га, Уул уурхайн компанийн хөрөнгөөр 23.7 га, Хаан банк өөрийн хөрөнгөөр 100 га, ойн мэргэжлийн байгууллагууд өөрийн хөрөнгөөр 214.3 га, орон нутгийн төсвийн хөрөнгөөр голын татмын доройтсон ойг хамгаалах, нөхөн сэргээх бургасан ойн ойжуулалт 3 суманд 8.9 га талбайд тус тус хийж, аймгийн хэмжээнд нийт 402.9 га талбайд ойжуулалт хийж 802.8 мянган тарьц тарьсан. Тус ажилд дээрх эх үүсвэрүүдээс нийт 1,322.9 сая төгрөг зарцуулж 335 хүнийг түр ажлын байраар хангасан.	1322.9	Холимог эх үүсвэр
		964. Ойн үрийн нөөцийг бүрдүүлэх	100%	100%	3 сум дундын ойн анги Нарсны үр 5кг, Шинэсний үр 21 кг, Хушны үр 150 кг болон навчит мод шар хуайс, монос, Голтбор, Гүйлс, Агч зэрэг навчит модны 28.5 кг, нийт 204.5 кг үр бэлтгэж нөөцөлсөн.	19.9	Орон нутгийн төсөв

			965. Ойн төлөв байдлыг тогтмол үнэлж, ойд арчилгаа цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх	100%	100%	Улсын төсвийн хөрөнгөөр I.II насны ангийн арчилгааны огтлолтыг Батширээт суманд 40 га, Биндэр суманд 15 га, орон нутгийн төсвийн хөрөнгөөр Өмнөдэлгэр суманд 20 га нийт 75 га талбайд хийсэн. 2.Улсын төсвийн хөрөнгөөр Өмнөдэлгэр суманд 100 га, Жаргалтхаан суманд 100 га талбайд ойн цэвэрлэгээний ажил, ойн мэргэжлийн байгууллага нийт 612 га талбайд ойн цэвэрлэгээний огтлолт, ойн нөхөрлөл, иргэд нийт 428 га талбайд ойн цэвэрлэгээний ажил тус тус хийсэн.	255.1	Холимог эх үүсвэр
		3.4.1.5. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулж, ойн хомстол, доройтлыг бууруулахад ухаалаг, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.	966. Ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажилд байгальд сөрөг нөлөө багатай ухаалаг, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	70%	70%	2024 оны жилийн эцсийн судалгаагаар 58600 га талбайд ойн хөнөөлт шавжийн голомт илэрсэн. Үүнээс Улсын төсвийн хөрөнгөөр Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Дадал, Норовлин, Баян-Адарга сумдын нийт 32000 га, орон нутгийн төсвийн хөрөнгөөр Батширээт, Өмнөдэлгэр сумдын 5500 га, нийт 37500 га талбайд ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажил хийгдэж нийт голомттой талбайн 63.9 хувийг хамрууллаа.	1245	Орон нутгийн төсөв
		3.4.1.7. Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, усны үнэ цэн, үнэлэмжийг нэмэгдүүлэн ашиглалт, хэрэглээнд хэмнэлт, дахин ашиглалтыг дэмжинэ.	968. Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг хийх	100%	100%	Чингис хотын ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2024 оны 06 сарын 24-нд эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажил хийгдэж дууссан ба судалгааны дагуу Хэрлэн голын хөвөөнд 10 худаг бүхий эх үүсвэрийг гарган, V=200м3 3ш нөөцийн сав байрлуулахаар тусгагдсан зураг төсөл Барилгын хөгжлийн төвийн 2024 оны 12 сарын 25-ны өдрийн 2397/2024 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажиж гарсан.	295	Орон нутгийн төсөв
			977. Газрын мониторингийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх	100%	100%	Энэ онд 198 нэгж талбарт газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил хийгдэн, газрын мониторингийн цахим системээр дамжуулан баталгаажуулаад байгаа бөгөөд нэгдсэн судалгааг загвар хүснэгтийн дагуу гарган 2025.10.20-ны өдрийн 02/664 дугаартай албан тоотоор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. Тус хугацаанаас хойш цахим системээр дамжуулан баталгаажсан тайлангийн нэгдсэн мэдээг 2025.12.20-ны байдлаар гарган, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэхээр бэлтгэж байна.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
		3.4.2.3. Хөдөө аж ахуй, газар тариалангийн бүс нутагт байгальд ээлтэй технологи нэвтрүүлж, нөхөн сэргээх, газар	978. Маш хүчтэй доройтсон газрын ашиглалтыг нэгдмэл сангийн ангиллаар тодорхойлох, нөхөн сэргээх	Х.Б	Х.Б	2025 он газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон тодотголоор батлагдан хэрэгжүүлж байгаа газар хамгаалах, нөхөн сэргээх, сайжруулах арга хэмжээ болон түүний санхүүжүүлэлтийн эх үүсвэрийн судалгааг гарган, ГХБХБГ-ын 2025.06.23-ны өдрийн 02/400 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хавсралтаар хүргүүлсэн. 2025 онд газар хамгаалах, нөхөн сэргээх, сайжруулах арга хэмжээний хэрэгжилтийн тайлан ГНСТ-10 маягтаар 2026.01.15-ны байдлаар гарна.	590	Холимог эх үүсвэр

3.4.2. Уур амьсгалын өөрчлөлт	тариалангийн хамгаалалтын зурвасыг нэмэгдүүлэх байгальд түшиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	979. Цөлжилтөд өртсөн газар нутгийг нөхөн сэргээх, элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах ажлыг хэрэгжүүлэх	100%	100%	Голын татмыг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор Баян-Овоо суманд 3 га, Батширээт суманд 5.4 га, Дэлгэрхаан суманд 0.5 га, нийт 8.9 га талбайд бургасан ойжуулалт, хөрсний элэгдэл эвдрэл, цөлжилт, салхинаас хамгаалах зорилгоор Батноров суманд 9.5 га, Баян-Овоо суманд 8.0 га, Баян-Адарга суманд 5.4 га, Дархан суманд 2.5 га, Баянмөнх суманд 2.5 га, Галшар суманд 2.5 га, Норовлин суманд 0.15 га, Бор-Өндөр суманд 18.0 га, Биндэр суманд 12.0 га, Жаргалтхаан суманд 1.0 га, Өмнөдэлгэр, Хэрлэн, Гурванбаян тосгонд тариалангийн талбайн 80 га, Мөрөн суманд ногооны талбайн 3.0 га, нийт 144.5 га талбайд ойн зурвас, Бор-Өндөр сумын цэвэрлэх байгууламжийн орчны 2 га талбайд 15.8 мянган мод тарьж, нийт 155.4 га талбайд хамгаалалтын ойн зурвас шинээр байгууллаа. Мөн "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд 12 сумын 52 хоршоонд 386.6 га атаршсан талбайг олгож ногоон тэжээл тариалж эргэлтэд оруулснаар 450 тн ургац хураан авсан.	1100.6	Холимог эх үүсвэр
	3.4.2.5. Усны чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг эрчимжүүлж, экологийн чухал ач холбогдолтой Хөвсгөл нуур, Ганга нуур, Өгий нуур, Хэрлэн гол зэрэг усны сан бүхий газрыг нөхөн сэргээж, хамгаална.	984. Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй зарим аймгийн төв болон хүн амын суурьшилд, иргэдийн хөдөлгөөний нягтаршил ихтэй сумдын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг хамгаалалтад авах	100%	100%	Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг шинэчлэн зурах ажлыг аймгийн хэмжээнд хийж гүйцэтгэсэн. Усны сан бүхий газар нь аймгийн нийт нутаг дэвсгэрийн 14.7%-ийг эзэлж байсныг 15.1% болгож өргөжүүлэхээр төлөвлөн нөлөөллийн бүсэд хэлэлцүүлэг, нөлөөллийн шинжилгээг зохион байгуулж тайланг гаргаад байна. Урсац бүрдэх эхийг хамгаалалтад авах судалгааны ажлыг, Цэнхэрмандал сум Цэнхэрийн голын эх, Онон голын эх, Улз голын эхэд хийн урсац бүрдэх эхийг орон нутгийн хамгаалалтад авах зөвлөмжийг боловсруулж холбогдох сумдад хүргүүлсэн. Голын татмыг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор Баян-Овоо суманд 3 га, Батширээт суманд 5.4 га, Дэлгэрхаан суманд 0.5 га, нийт 8.9 га талбайд бургасан ойжуулалт хийсэн. Мөн Хэрлэн голын урсцыг сайжруулах цутгал голуудыг тэтгэх зорилгоор Хэрлэн голын сав газарт Мөрөнгийн голд 1 хөв цөөрөм байгуулж, 4 хөв цөөрөм шинээр байгуулах зураг төсвийг хийлгээд байна. Чингис хот, Бор-Өндөр, Дэлгэрхаан сумдын ундны усны эх үүсвэрийн худгууд дотоодын цэргийн хамгаалалтад бүрэн шилжсэн. Чингис хотын ундны усны эх үүсвэрийн байгууламжид хлоржуулалтын төхөөрөмж ажиллаж ариутгал, халдваргүйжүүлэлт хийж байна.	367.5	Холимог эх үүсвэр

3.4.2.7. Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй амьдралын хэв маяг, хандлага, дадлыг хэвшүүлнэ.	991. Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй амьдралын хэв маяг, хандлагын талаар олон талт нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж, идэвх оролцоог дэмжих	100%	100%	Хавар, намрын "Тэрбум мод тарих өдрүүд" арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 13.7 мянган хүн, 2.8 мянган айл өрх, 160 аж ахуйн нэгж, байгууллагыг уриалан мод тарих ажилд оролцуулж, хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хог хаягдлын талаарх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Хог хаягдлын зохистой зохицуулах систем ба тэг хаягдлын зарчимд шилжих нь" "Хогоо багасгая, ангилъя, дахин боловсруулцгаая", "Хаявал хог ангилбал баялаг" зэрэг сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж 60 гаруй байгууллага, аж ахуйн нэгжийн 400 орчим иргэдийн идэвх оролцоог хангаж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй амьдралын хэв маяг, хандлагыг бий болгоход нөлөөлж ажиллалаа. Байгаль орчинд ээлтэй, утаагүй, дулаан алдагдалгүй, түүхий нүүрс, мод түлээний хэрэглээгүй, хүүхэд, эмэгтэйчүүдэд ээлтэй эрүүл, аюулгүй амьдралын хэв маяг, хандлагыг бий болгох "Монгол гэрийн халаалт, дулаалга, агаар сэлгэлтийн Чип багц" төслийн танилцуулга мэдээлэл, үр дүнг иргэд олон нийтэд танилцуулах, үйлдвэрлэгчдийг дотооддоо бэлтгэх чиглэлээр олон талт нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж, 600 гаруй иргэдэд мэдээлэл хүргэсэн. 2 оёдлын цехийн 3 оёдолчныг Чип багц үйлдвэрлэх технологийн болон дадлага сургалтад хамруулж сертификат олгосон ба орон нутагт үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах эрх авсан.	1300	Орон нутгийн төсөв
3.4.2.8. Уул уурхайн нөхөн сэргээлтийн чанар, хяналтыг сайжруулж, нөхөн сэргээлт хийгээгүй хуулийн этгээдэд ногдуулах хариуцлагыг чангатгана.	992. Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу тогтмол чанартай хийлгэх	100%	100%	Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын хөрөнгөөр 2025 онд уул уурхай, дэд бүтцийн нөлөөгөөр эвдрэлд орж эзэнгүй орхигдсон Дархан сумын 15 га талбайг 20.0 сая төгрөгөөр, Бор-Өндөр сумын 5 га талбайг 10.0 сая төгрөгөөр, Батноров сумын 6-р багийн нутаг дэвсгэрт 8.8 га талбайг аж ахуй нэгжийн 20.0 сая төгрөгөөр, нийт 28.8 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгүүлсэн.	50	Холимог эх үүсвэр

		3.4.2.9. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хот, суурин газруудад яндангүй бүс байгуулж эрчим хүч, усны ухаалаг хэрэглээтэй амины орон сууцны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.	993. Аймгийн төвүүд болон хот, суурин газрын агаарын чанарыг сайжруулах яндангүй бүсийг тогтоож, мөрдүүлэх	90%	90%	Чингис хотын агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн бүсэд мөрдөх журмыг боловсруулан, Захиргааны ерөнхий хуулийн дагуу зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэг, нөлөөллийн шинжилгээ, тайлан мэдээний хамт БОУАӨЯаманд хүргүүлж Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, аймгийн Засаг даргын хамтарсан шийдвэр А/830, А/583 дугаартай тушаал/захирамжаар батлуулсан. Журамд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх 18, төрийн байгууллагуудын дагаж мөрдөх 9 эрх, үүргийг тусгасан ба хариуцсан байгууллагуудад чиглэл өгч хэрэгжилтийг 90 хувьтай хангуулан ажиллаж байна.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
		3.4.3.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудитын үр дүнд суурилсан, хүрээлэн буй орчин, хүнд ээлтэй орчныг төлөвлөж, нийгэм, эдийн засгийн ногоон хөгжлийн загварыг бий болгоно.	990. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинжилгээг үр дүнтэй хийж, аливаа төслөөс хүрээлэн байгаа орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, ногоон технологи нэвтрүүлэх чиглэлээр байгаль орчныг хамгаалах менежментийн	70%	70%	БОНБНҮнэлгээний тайлан батлуулсан 49 аж ахуй нэгжийн 2025 онд хэрэгжих байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг батлуулахаар БОУАӨЯаманд хүргүүлснээс буцаагдсан 22 төсөл, батлагдсан 27 төсөл байна. Батлагдсан 27 төслийн 2025 оны байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хуулийн хугацаанд багтаан дүгнэж ажиллаж байна. Байгаль орчны газар нийт 40 төсөлд байгаль орчны нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийгээд байна.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
		3.4.3.3. Орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	999. Хөрсний нянгийн болон хүнд металлын бохирдлын судалгаанд үндэслэн бохирдол ихтэй газруудад бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	100%	100%	Аймгийн хэмжээнд 16104 ш нүхэн жорлон тоологдож, шаардлага хангасан АЦБ 2031ш байна. Нүхэн жорлонг бууруулж, стандарт шаардлага хангасан АЦБ нэмэгдүүлэх төлөвлөгөөг батлуулж ажилласан ба энэ онд 14 шатахуун түгээх станц техникийн ерөнхий шаардлага MNS 4628.2013 стандартад нийцсэн АЦБ-тай болсон. Мөн 12 сумдад цэвэрлэх байгууламж баригдаж, ашиглалтад оруулснаар 6 суманд 38 төрийн байгууллага, 3 суманд 96 айлын 4 блок орон сууцны барилга төвийн шугамд холбогдож, нүхэн жорлонгүй болсон. Нийт 415 нүхэн жорлонг дарж булан, 198 нүхэн жорлонг стандарт шаардлагад нийцүүлснээр шаардлага хангасан АЦБ-ийн тоог 2229 хүргэж нүхэн жорлонгоо сайжруулсан айл өрх, ААНБ-ын эзлэх хувь 9% болж нэмэгдсэн. Хэрлэн сумын 1,2,3,4,5-р багт гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажил УТХОруулалтаар үе шаттай хийгдэж байна. 5 багийн нийт 5000 гаруй айл өрх дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээнд холбогдох боломжтой бөгөөд ашиглалтад орсноор иргэд хашаандаа аятай тухтай амьдрах нөхцөл бүрдэж, 5000 гаруй айл өрхийн яндан, нүхэн жорлонгийн тоо буурч агаар, хөрс, орчны бохирдол багасна.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй

3.4.3. Ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн загвар	3.4.3.5. Цэвэрлэх байгууламж, гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн лагийг байгальд ээлтэй аргаар устгах туршилтын төсөл хэрэгжүүлнэ.	1005. Цэвэрлэх байгууламжийн 1000 м3 лагийг бордоо болгож уул уурхайн нөхөн сэргээлтэд ашиглах туршилтын төсөл хэрэгжүүлэх	100%	100%	Бор-Өндөр сумын Цэвэрлэх байгууламж нь өдөрт дунджаар 1500–1800 м³ бохир ус хүлээн авч, түүнээс 1200 м³ орчим саарал ус боловсруулан гаргадаг. Боловсруулсан саарал усыг төмөр баяжуулах үйлдвэрийн хүдэр угаах зориулалтаар жил бүрийн 5 -10 дугаар сарын хооронд борлуулж, байгальд ээлтэй аргаар ашигладаг.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
	3.4.3.7. Тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг нэвтрүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин, Үндэсний ногоон барилгын үнэлгээний систем нэвтрүүлж, хөгжүүлнэ.	1014. Ногоон зээлийн бүтээгдэхүүний нэр төрөл, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх	100%	100%	"Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж буй арилжааны 4 банкны салбар, нэгжүүдийн ногоон зээлийн үлдэгдэл 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 1.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өссөн үзүүлэлттэй байна. Арилжааны банкууд ногоон зээлийн олон нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, иргэд, аж ахуй нэгжид үйлчилж байна. - Хас банк нь эрчим хүчний хэмнэлттэй хэрэглэх "ЭКО амины орон сууцны зээл"-ийн бүтээгдэхүүнээр 2 иргэд үйлчилж 227.6 сая төгрөгийн ногоон зээл - Төрийн банк "Ухаалаг байшин" ногоон зээлийн бүтээгдэхүүнээр иргэдэд үйлчилж "Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зориулалтаар 1 иргэнд 115.3 сая төгрөгийн зээл - Хаан банк нь 3 иргэнд 1130.0 сая төгрөгийн сэргээгдэх эрчим хүчний хэмнэлттэй ногоон зээлийг тус тус олгосон. 3-р улирлын байдлаар: - Сэргээгдэх эрчим хүч 242.8 сая, - Ногоон барилга ЭЭХ-ны АОС- 259.8 сая.төг, - Карбон тээвэр-702.2 сая.төг, - Эрчим хүчний халаагуур-4.0 сая.төг, - Бохирдлоос сэргийлэх үйл ажиллагаа-7.9 сая.төг, - Тогтвортой ХААН-н, газар ашиглалт -13.4 сая.төг, - ЭКО аялал жуучлал - 61.3 сая.төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй

3.4.3.8. Энгийн болон аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах оновчтой менежментийн тогтолцоог бүрдүүлнэ.	1015. Аймаг, нийслэл, сум, суурин газарт эрүүл ахуйн шаардлага хангасан төвлөрсөн хогийн цэгийг байгуулах	100%	100%	Баян-Овоо, Батширээт, Дэлгэрхаан сумд орон нутгийн төсөв, хөгжлийн сангийн 410.0 сая төгрөгийн хөрөнгөөр сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийг стандартын дагуу цэгцлэх, дарж булах, тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулсан. Хог хаягдлын талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 25 сургагч багш, 81 сурагчдыг давтан сургалтанд, сумдын Засаг дарга, БОХУБ, байгаль хамгаалагч нарыг хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулах, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг оновчтой зарцуулах аргачлалд суралцуулах сургалтанд хамруулсан. Аймгийн нутаг дэвсгэрт хүнсний бөөний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг MCS ХХК, Витафит ХХК, Апу ХХК зэрэг томоохон үйлдвэрлэгчдийн Хэнтий салбараас худалдан борлуулсан бараа бүтээгдэхүүний судалгааг авч үүсгэж буй хог хаягдлын хэмжээг тогтоож, дахивар хог хаягдлыг эргүүлэн татах менежментийг хэрэгжүүлэх зорилгоор "Хаявал хог ангилвал баялаг" аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгч ААН, төрийн болон бусад байгууллагууд нийт 27ш дахивар хог ангилан ялгах хогийн савыг аймгийн төвд, нийтийн эзэмшлийн зам талбайд байршуулсан ба үүний үр дүнд хуванцар, гялгар уут, лааз 58.8тн, архины шил 30.0 мян/ш, цаасан хайрцаг 10.0 мян/ш дахивар хог хаягдлыг эргүүлэн цуглуулж, дахин ашиглах, дахин боловсруулах үйлдвэрүүдэд тушааж нийт хог хаягдлын 1.4%-ыг эдийн засгийн эргэлтэнд оруулсан.	490	Орон нутгийн төсөв
---	--	-------------	-------------	---	------------	---------------------------

		3.4.3.10. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилгоор эрчим хүч, ус, бохирын хувьд бие даасан, байгальд ээлтэй, зөөврийн орон сууцны технологийн судалгаанд хөрөнгө оруулалт хийнэ.	1020. Пассив, тэг барилга зэрэг эрчим хүч, материалын хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилгын шийдлийг туршин нэвтрүүлэх загвар төслүүдийг хэрэгжүүлэх	100%	100%	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ-ыг ЦЭХ-ээр хангах 60квт-ын нарны эх үүсгүүр суурилуулан ашиглалтад оруулсан ба Цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга бага чадлын 2кВт хүчин чадалтай нарны эх үүсгүүр суурилуулж аваарын үед ашиглаж байна. Мөн 2025 онд шинээр баригдахаар төлөвлөгдсөн 46 барилгад архитектур төлөвлөлтийн даалгавар, 20 төсөл арга хэмжээний зургийн даалгавар боловсруулагдаж баталгаажсан бөгөөд даалгавар тус бүрд “Ногоон хөгжлийн бодлого, ногоон барилгын шаардлагыг хэрэгжүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх” шаардлагыг тусгаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Цэнхэрмандал сумын Бүрэн уулын орчим Хэрлэн голд Нэгдсэн сүлжээний горим тохируулах үүрэг бүхий 100МВт хүртэл хүчин чадалтай усан цэнэгт цахилгаан станцын ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нээлттэй зарлаад байна. 2025 онд Хэнтий аймаг дахь Төрийн аудитын барилгын зураг төсөл мөн эрчим хүчний хэмнэлттэй технологийн дагуу боловсруулагдсан.	550	Холимог эх үүсвэр
		3.4.3.11. Орхон-Онги, Хэрлэн-Тоонот ус дамжуулах хоолойг барина.	1021. Орхон-Онги, Хэрлэн-Тооно усан сан, ус дамжуулах хоолой барих ажлыг эхлүүлэх	Х.Б	Х.Б	“Хэрлэн-Тооно” төслийн ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулах төслийн гүйцэтгэгч Монхидроконстракшн ХХК-тай уулзалт зохион байгуулж мэдээлэл солилцсон. Ус дамжуулах шугамын дагуу байрлах сумдын хилийн цэс, орон нутгийн хамгаалалттай газрын мэдээллийг хуваалцсан. Мөн Дэлгэрхаан сумын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд уулзалт хэлэлцүүлэг болон "Хэрлэн голын сав газар дахь уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн үнэлгээ түүнд дасан зохицох арга зам" сургалт хэлэлцүүлгээр тус тус мэдээлэл хүргэж ажилласан. Тус аймаг нь төсөл хэрэгжүүлэгч биш тул хасуулах саналтай.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								
4.1. Хүний эрх, эрх чөлөө								

			1064. Төрийн болон орон нутгийн өмчийн асуудал хариуцсан байгууллагын чадавхыг бэхжүүлэх	100%	100%	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2025 оны байдлаар Орон нутгийн өмчийн газрын хяналт шалгалт хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалт, шинэ систем нэвтрүүлэхтэй холбоотой сургалт, өмчийн удирдлага болон компанийн засаглалын тухай, бүсийн зөвлөгөөн зэрэг 4 удаагийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг танхимаар зохион байгуулахад тус газраас давхардсан тоогоор 7 албан хаагч хамрагдсан. Мөн ТӨБЗГ-с цахимаар 2 сургалтыг зохион байгуулахад бүх албан хаагч хамрагдсан. Мөн Сүхбаатар аймаг руу Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэгт Орон нутгийн өмчийн газар хамрагдаж Сүхбаатар аймагт очиж туршлага солилцсон. Тус газрын зүгээс орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудад шинэ систем хэрэгжүүлэхтэй холбоотой, үндсэн чиг үүргийн хүрээнд холбогдох сургалтыг аймгийн төвийн байгууллагуудад танхимаар, сумдад цахимаар тус тус зохион байгуулж мөн аймгийн төвийн байгууллагыг салбараар нь буюу боловсрол, эрүүл мэнд, соёлын салбараар нэгтгэж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, мөн хойд сумд болох Батширээт, Биндэр, Баян-Адарга, Норовлин, Дадал, Батноров, Мөрөн зэрэг 6 суманд биечлэн очиж газар дээр нь байгууллагуудад зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан. Жилийн эцсийн байдлаар нийт 12 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласан.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
4.1.4.	Ил тод байдал	4.1.4.2. Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах						

	4.2.1. Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа	4.2.1.12. Эрүүл, аюулгүй орчныг бий болгох зорилгоор камерын хяналтын нэгдсэн системийг суурьшлын бүсийн 80 хувьд хүргэнэ.	1101. Улсын хэмжээнд камерын хяналтын тогтолцоог хөгжүүлж, мэдээллийг цаг алдалгүй авч шинжилгээ хийх төвийг байгуулах	100%	100%	Телекамер хяналтын дэд төв нь Хэнтий аймаг Чингис хотын хэмжээнд суурилагдсан гудамж талбайн хяналтын камерын тасралтгүй ажиллагааг хангах, камераар хяналт тавьж цагдаагийн байгууллагад ирсэн гомдол мэдээллийн дагуу бичлэг нягтлах, шалгах чиглэлээр үйл ажиллагааг явуулж байна. Одоогийн байдлаар Чингис хотын хэмжээнд 75 цэгт 230 камер суурилагдсан байгаагаас 2025 оны 3-р улиралд 15 цэг 60 камер шинээр суурилагдсан байна. Хэнтий аймгийн хэмжээнд сумдын камержуулалтыг нэгдсэн стандартад нийцүүлэх, цаашлаад телекамер хяналтын дэд төвд холбох талаар сумдууд болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр эхлүүлээд байна. Чингис хотын 150 хувийн хэвшлийн гадна талбайн камерыг дэд төвд холбох ажлыг Юнивишн ХХК - тай байгуулсан гэрээний нөхцлийн дагуу холбох ажлыг эхлүүлэн хувийн хэвшлүүдтэй гэрээ байгуулж ажиллаж байна. Ингэснээр аймгийн хэмжээний гудамж талбайн хяналтын камерын тал хувь хиймэл оюун ухаанд суурилсан зөрчил илрүүлэх систем болон ажиллах давуу талтай. Мөн Чингис хотыг ногоон бүс болгох зорилго бүхий 422 цэгт 1600 камер суурилагдах ажлын зургийг Ар бэл Алтай компанитай хамтран хийж 2025 онд хийж гүйцэтгэсэн бөгөөд цаашид хэрэгжүүлэх тал дээр анхааран ажиллаж байна.	433	Орон нутгийн төсөв
		4.2.2.2. Төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг дээшлүүлж, иргэдэд түргэн шуурхай, хялбар үйлчилгээ үзүүлэх цахим төрийн тогтолцоонд шилжинэ.	1116. Газар зүйн нэрийн тодруулалт хийж мэдээллийн сан бүрдүүлэх, иргэд, байгууллагыг үнэн зөв газар зүйн нэрийн лавлагаа мэдээллээр хангах	90%	90%	Аймгийн 18 сум, 3 тосгонд төрийн цахим лавлагаа, үйлчилгээний 24/7 киоск төхөөрөмжийг байршуулж, алслагдмал бүсэд амьдарч буй иргэд төрийн үйлчилгээг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран ойроос авах боломжийг бүрдүүллээ. Сумдын “Хурдан” цэгийн техник тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн ажиллах нөхцөлд өдөр тутам хяналт, шаардлага тавин, операторын эрхгүй албан хаагчдад албан ёсны эрхийг үүсгүүлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна. Газар зүйн нэрийн тодруулалтын ажлын даалгавар Батширээт сум хийгдэж дууссан. Өмнөдэлгэр, Дадал сумдын Газар зүйн нэрийн тодруулалтын ажлын даалгавар боловсруулалтын шатандаа явж байна. Цэнхэрмандал сумын боловсруулалт хийх ажил дууссан ба сумын ИТХ-аар батлуулахаар хүлээгдэж байна.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй

	4.2.2. Дэвшилтэт технологид суурилсан цахим засаглал	4.2.2.3. Төр хувийн хэвшил, иргэний нийгэмтэй хамтран ажиллахыг эрэлхийлдэг, тэдгээрийн оролцоог шийдвэр гаргах үйл явцдаа хангаж, ил тод байдлыг бий болгосон төрийн шинэ тогтолцоог бий болгоно.	1122. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн бэлтгэл ажлын явцад хувийн хэвшил, салбарын иргэний нийгмийн байгууллага, тухайн төсөл хэрэгжих орон нутгийн оролцоог хангаж, бүрэн шинжилгээний дүгнэлтэд тусгах	100%	100%	Монголын технологи шинжлэх ухаан эмэгтэйчүүдийн НҮТББ, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран Кибер аюулгүй байдлын талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийт 5 удаагийн сургалт, уулзалтыг зохион байгуулж нийт 735 иргэнийг хамрууллаа. Сургалтын явцад кибер орчны эрсдэл, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах арга зам, цахим хэрэглээний зөв дадал хэвшүүлэх чиглэлээр мэдлэг олгож, олон нийтийн дунд кибер аюулгүй байдлын нөлөөллийн ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна. Төрийн байгууллагын мэдээлэл технологийн ажилтан, албан хаагчидтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж 60 орчим IT, мэдээллийн технологийн ажилтнууд хамрагдсан болно. Уулзалт хэлэлцүүлгийн хүрээнд төрийн байгууллагын нэгдсэн мэдээллийн систем болох www.gov.mn дээр бүртгэгдэх, мэдээлэл оруулах талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. Бүх нийтийн цахим ур чадварын 5 дугаар аяны хүрээнд салбар салбарын цахимжилтыг хэлэлцэх, төрийн цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг таниулах, нэмэгдүүлэх, бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг таниулах зэрэг зорилгын дор ТВ-ийн цуврал хэлэлцүүлгийг хийх бэлтгэл ажлыг хангаад байна. Хэлэлцүүлэгт 5-6 эх сурвалж бүхий бодлогын, хэрэгжилтийн байгууллагууд болон үйлчилгээ хүртэгч иргэд, олон нийтээс хамруулан оролцуулж байхаар төлөвлөж байна.	12	Орон нутгийн төсөв
	4.2.3. Төрийн албаны реформ шинэчлэл	4.2.3.9. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтлан орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлнэ. Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч буй иргэд хөдөлмөр эрхлэх, жижиг, дунд, бичил бизнесийн салбарт ажиллах, орлого олох, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ.	1153. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан төрийн албан хаагчдад зориулан түрээсийн орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх	90%	90%	ХББОСЯамнаас хэрэгжүүлж буй "Төрийн албан хаагчдын орон сууцны цогц хөтөлбөр"-т Жаргалтхаан суманд Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууц, Хэрлэн, Биндэр суманд Төрийн албан хаагчдын 15 айлын орон сууц баригдахаар 3 сум хамрагдсан. Жаргалтхаан сумын Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны барилга угсралтын ажил 3-р улиралд эхэлсэн бол Хэрлэн, Биндэр сумын Төрийн албан хаагчдын 15 айлын орон сууцны төслийн гүйцэтгэгч энэ оны 3-р улиралд шалгарч зураг төслийн шатандаа явж байна. Мөн төрийн албан хаагчийг түрээсийн орон сууцаар хангах зорилтын хүрээнд Хэрлэн сумын 4 дүгээр багт баригдаж буй "Хэнтий Стандарт" хорооллын 4 блок орон сууцны барилгаас блок тус бүрээс 1 өрөө байр авах талаар хэлэлцээр хийсэн.	3600	Улсын төсөв

	4.3.1. "E-Mongolia"-блокчейн-Цахим засаглал	4.3.1.5. Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэл, газрын хэвлийн баялаг болон газар дээрх баялгийн бүртгэлийг "блокчейн" технологийг ашиглан гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.	1195. Гудамж, нэгж талбар, барилга байгууламжийг батлагдсан стандарт, нормын дагуу тэмдэгжүүлэх	30%	30%	Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд аймгийн төрийн байгууллагуудаас И-монголиа системд шинээр оруулах үйлчилгээний санал болон иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний судалгаа ирүүлэх тухай 9/1034 дугаартай албан тоотыг 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр төрийн байгууллагууд руу илгээн судалгааг авч нэгтгэж ажилласан болно.Мөн Хурдан киоск төхөөрөмжид оруулах 10 шинэ үйлчилгээний саналыг авч нэгтгэсэн болно. Судалгаа мэдээллийг дор бүр нь албан мэдээлэл, судалгаанд нэгтгэж ажиллав.2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 11 орон сууц, барилга байгууламжид хаяг дугаар өгч ажилласан	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
4.4. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм								
	4.4.1. Үндэсний эв нэгдэл	4.4.1.9. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлт, хэрэглээтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хууль бус эргэлттэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлого, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүхий л үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлүүлэх, мансуурах донтой хүнд олон улсын стандартад нийцсэн эрүүл мэнд, нийгэм хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, эмчлэх, хяналтад авах, нийгэмшүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	1251. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх сургалтыг эрсдэлт бүлгийг тодорхойлж, зохион байгуулах	70%	70%	Хэнтий аймгийн хэмжээнд мансууруулах үйлчилгээтэй /каннабис/ ургамлын тархац тогтоогдсон нутаг дэвсгэрт зэрлэг байдлаар ургаж байгаа ургамлын ургаж буй цэг, байршлыг биечлэн тандан судлах, “Устгал-2025” нэгдсэн арга хэмжээнд аймагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс 7 сая төгрөг шийдвэрлүүлэн устгалыг аймгийн хэмжээнд зохион байгуулах 3 бүлэг 15 заалт бүхий төлөвлөгөө гарган Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт зэрлэг байдлаар ургаж буй олсны ургамлыг устгах ажлыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсан.	7	Орон нутгийн төсөв

			1330. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх	100%	100%	Үндэсний Батлан хамгаалахын их сургуульд 2025 оны 09 дүгээр сард 14 хоногийн хугацаатай явагдсан бэлтгэл офицерын сургалтад 3 хүнийг хамруулан дайчилгааны даалгаварт оногдуулан бүртгэж бэлтгэл офицерын мэргэжил, чанарыг байдлыг нэмэгдүүлсэн. Цэргийн дайчилгааны даалгаврын дагуу оногдуулан бүртгэлтийг 2025 оны 2, 4 дүгээр улиралд 2 удаа тодотгож тайлан мэдээг ЗХЖШ-ын БСТГ-т хүргүүлсэн.	6	Орон нутгийн төсөв
			1331. Дайчилгааны бэлтгэл үүрэгтний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах	100%	100%	Үндэсний Батлан хамгаалахын их сургуульд 2025 оны 09 дүгээр сард 14 хоногийн хугацаатай явагдсан бэлтгэл офицерын сургалтад 3 хүнийг хамруулан дайчилгааны даалгаварт оногдуулан бүртгэж бэлтгэл офицерын мэргэжил, чанарыг байдлыг нэмэгдүүлсэн. Цэргийн дайчилгааны даалгаврын дагуу оногдуулан бүртгэлтийг 2025 оны 2, 4 дүгээр улиралд 2 удаа тодотгож тайлан мэдээг ХЖШ-ын БСТГ-т хүргүүлсэн.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
4.4.3. аюулгүй батлан тогтолцоо	Үндэсний байдал, хамгаалах	4.4.3.3. “Сөрөн тэсвэрлэх чадавх - Батлан хамгаалах тогтолцоо” -ны хүрээнд батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг хангаж, дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болгож, иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлнэ.	1332. Иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах	100%	100%	- ЕБС-ийн 9-12 дугаар ангийн сурагчдын ирээдүйн мэргэжлээ сонгоход нь туслах зорилгоор Төрийн цэргийн болон хууль, сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж нийт 250 гаруй сурагч, 100 гаруй иргэд уг арга хэмжээг сонирхож өөрт хэрэгтэй мэдээллийг авч байлаа. - Алдар спорт хорооноос томилогдсон бүрэлдэхүүнтэй хамтран ЕБС-ын ахлах ангийн сурагчдын дунд "Эх оронч Монгол-Их сэргэлтийн жил"-ийн хүрээнд хийгдэж байгаа ажил арга хэмжээг сурталчлах, уралдаан тэмцээн зэргийг зохион байгуулж хамтран ажиллалаа. - Монгол улсад Цэргийн дээд цол болох "Генерал" цол олгож эхэлсний 81 жилийн ойн хүрээнд аймгийн музейд Хэнтий аймгаас төрөн гарсан болон Хэнтий аймагт ажиллаж амьдарч байсан генерал цолтнуудын танхим байгуулж нээлтийг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хийсэн. - “Олон Улсын энхийг сахиулагчдын өдөр”-ийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аймгийн төвийн ерөнхий боловсролын 5-н сургуулийн төлөөлөл 100 гаруй сурагчдад Эх оронч үзэл, Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд сэдвээр Зэвсэгт хүчний 232 дугаар анги болон дотоодын цэргийн алба хаагчидтай хамтран яриа танилцуулга хийсэн. - Аймгийн Засаг даргын нэрэмжит Цэрэг-спортын “Дөл-2025” тэмцээнийг 05 дугаар сарын 10-ны өдөр баг, тамирчдын аюулгүй байдлыг ханган, амжилттай зохион байгуулж явууллаа. Тус тэмцээнд 7 сумын 12 сургуулийн	24	Орон нутгийн төсөв

		4.4.3.9. Бүсийн сургалтын төвүүдийг шинээр байгуулж “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах суралцагчдын тоог шат дараатай нэмэгдүүлэн улс орны батлан хамгаалах чадавхыг дээшлүүлнэ.	1369. "Оюутан цэрэг" цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах суралцагчдын тоог шат дараатай нэмэгдүүлэх	100%	100%	Хэнтий аймаг Чингис хотод үйл ажиллагаа явуулдаг Политехникийн коллежоос “Оюутан цэрэг” цэргийн мэргэжил олгох сургалтад суралцах хүсэлтээ өгсөн оюутнуудыг МУ-ын ЗГ-ын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 85 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу бүртгэлийг зохион байгуулж, эрүүл мэндийн урьдчилсан үзлэгээр оруулж тэнцсэн оюутнуудаас бие бялдрын шалгалт авч 11 оюутны нэрийг БХЯ-ны ОНХДГ-т хүргүүлсэн. Аймгийн төвд “Цэргийн ерөнхий бэлтгэл шатны сургалтыг 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн 7 хоног бүрийн бямба, ням гарагуудад өдрийн 8 цагийн багтаамжтай явуулж нийт 96 цаг буюу 2 кредит хичээлийн хөтөлбөрийг танхимд онол дадлагын хэлбэрээр явуулж 06 дугаар сарын 8 өдөр оюутан цэргүүдийн танхимын хичээл дуусаж 2 дугаар шатны сургалт болох мэргэжлийн бэлтгэл шатны сургалтад хамруулхын өмнө эрүүл мэндийн үзлэгээр оруулж 1 оюутан эрүүл мэндийн шалтгаанаар хасагдсан. Зэвсэгт хүчний 327 дугаар ангид 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр 10 оюутан цэргийг хүргэн өгч 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Цэргийн тангараг өргөх ёслолын ажиллагаанд Цэргийн штабын дарга оролцсон. Оюутан цэргийн албаа амжилттай хаасан 10 оюутан цэргийг 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэсэн. Оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутнуудыг ая тухтай сургалтын байранд суралцуулах талаар анхаарч Политехникийн коллежийн байранд сургалтын танхим гаргаж тусгайлан тохижуулж, нээлтийг 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж нээлтийн арга хэмжээнд	6	Орон нутгийн төсөв
--	--	---	---	-------------	-------------	---	----------	---------------------------

	4.4.4. Гамшгийн үеийн бэлэн байдал	4.4.4.4. Гал түймэр унтраах болон эрэн хайх, аврах нэгжийг орон нутагт өргөтгөж, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	1376. Гал түймэр унтраах болон эрэн хайх, аврах нэгжийг орон нутагт өргөтгөж, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах	100%	100%	Баян-Овоо сумын Гүрмийн нуурын эрэгт төрийн байгууллагын хэрэгцээнд 1 га газрыг шийдвэрлүүлж, тогтмол уснаас эрэн хайх, аврах дадлага сургуулийг явуулах 5х4 харьцаатай 3 дүнзэн байшинг “Усны дадлага сургалтын төв”-ийн зориулалтаар байгуулж ашиглалтад орууллаа. Тус сургалтын төвийг Онцгой байдлын ерөнхий газрын дэмжлэгтэйгээр өөрсдийн дотоод нөөц боломжид тулгуурлан барьж байгуулсан. Мөрөн сумын “Эхэн Ус” гэдэг газар аймгийн төвөөс 35 км зайд байрлах байгалийн тогтоц бүхий уулархаг бүсэд төрийн байгууллагын хэрэгцээнд 1 га газрыг шийдвэрлүүлж “Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага сургалтын төв”-ийг хашаажуулах зардлыг аймгийн Засаг даргын 2026 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 30 сая төгрөг тусгуулаад байна. Хэнтий аймгийн хэмжээнд Эрэн хайх аврах салбар, Гал унтраах анги салбар нэгж шинээр байгуулагдаагүй, 2024 оны 06 сарын 18-нд Онцгой байдлын ерөнхий газраас гамшиг осолтой тэмцэхэд зориулж Л-200 маркийн суудлын автомашиныг шуурхай албанд зориулан ашиглуулахаар хүлээлгэн өгсөн.	0	Санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй
Үнэлгээний дундаж				88.66%	88.04%			